

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-45

-
- | | |
|--|-------|
| 1. Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.26-ны өдөр өргөн ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/ | 5-22 |
| 2. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/ | 22-43 |
| 3. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл | 44-45 |
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
9 дүгээр сарын 29-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Анар, Ч.Лодойсамбуу;
Томилолттой: Ш.Бямбасүрэн, С.Цэнгүүн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар;
Тасалсан: Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.26-ны өдөр өргөн ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунтуул, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, мөн эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн зөвлөх Д.Мөнгөнчимэг, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Т.Пүрэвхатан нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, М.Бадамсүрэн, Б.Тулга, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Г.Очирбат, Б.Заяабал, П.Батчимэг, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Т.Пүрэвхатан нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга Н.Нарангэрэл, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Баянмөнх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн мэргэжилтэн У.Марал, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, М.Бадамсүрэн, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Б.Тулга, Г.Очирбат, Г.Лувсанжамц, Л.Соронзонболд, Б.Заяабал нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Онцгой байдлыг ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга уг асуудлын санал хураалтыг хойшлуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тулд уг асуудлын санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 19 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 8

Бүгд: 23

65.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн Байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Ё.Энхсайхан, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат ажлын цаг дууссан тул Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 11

Бүгд: 23

52.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав./19:53/

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 36 минут үргэлжилж, 32 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
17 цаг 17 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Та бүгдийгээ хүлээлгэсэнд уучлалт хүсье. Танхим сулрахгүй байснаас хүлээлгэчихлээ. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батболд, Батсүмбэрэл, Батчимэг, Ганзориг, Жаргалан, Заяабал, Лувсанжамц, Мандхай, Найдалаа, Очирбат, Пунсалмаа, Соронзонболд, Сэддорж, Тулга, Уянга, Энхцэцэг, Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56,3 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газраас 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

2.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ирүүлсэн зөвшилцөх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

3.“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

4.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал нэг.

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Сайдын микрофоныг нээе. Чинбүрэн сайдын микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлд “Зүрх судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулна” гэж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 3 дугаар зүйлд “Зүрх судасны үндэсний төвийг барих” гэж тус тус заасан. Үүний дагуу Засгийн газрын зүгээс Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 34,9 сая ам.доллар-ын зээл болон Люксембургийн Их Гүнт улсаас олгох 22,5 сая евро, 26,4 сая ам.доллар-ын буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөн хэлэлцээрийг хийгээд байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банктai байгуулах зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд тус зээл нь баталгаат овернайт санхүүжилтийн хүү дээр 1,6 хувийн нэмэгдэл хүүтэй, 18 жилийн хугацаанд эргэн төлөгдөх, үүнээс 4 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байна.

Тус төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх судасны эмнэлгийн барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж, жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчлөл, нас баралтын хэмжээг бууруулах өндөр ач холбогдолтой байна.

Энэхүү зээлийн хэлэлцээрийг 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, гэрээний төсөл, танилцуулга материалыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Та бүхэн Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Хүрэлбаатар Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Төмөр-Очир Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн захирал, Мөнгөн-Өлзий Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн дарга, Мөнгөнчимэг Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн зөвлөх, Ариунтуул Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Пүрэвийн Батчимэг гишүүнээр тасалъя. Тулга гишүүнийг нэмье. Ирцийн дарааллаар эрэмбэлэгдсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Батболд асуулт асууж, үг хэлнэ.

Р.Батболд: Оройн мэнд хүргэе. Та нарыг маш их хүлээлгэчихлээ. Тэгэхээр энэ эмнэлэг байгуулах гэж байгаа явдал нь бол болж байгаа байх. Зүгээр энэ зээл тусламж 2 яваад байна. Монголын талаас санхүүжилт байгаа юу гэдэг нэг асуудал.

2 дахь нь энэ барилга байгууламждаа хэдэн доллар юм уу, еврог нь зарцуулах юм. Тоног төхөөрөмж нь хэд байх юм. Энийг хариулж өгөөч.

Р.Сэддорж: Чинбүрэн сайдад хариулъя.

Ж.Чинбүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Ер нь эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын санхүүжилт анх удаагаа 5,5 дахин нэмэгдэх гэж байна. Хэрвээ та бүхэн Азийн хөгжлийн банкны болон энэ Сэргээн босголтын банкны зээлийг дэмжиж санал өгвөл эрүүл мэндийн салбарын санхүүжилт 5,5 орчим хувиар нэмэгдэх бас түүхэнд байгаагүй том хөрөнгө оруулалт болох гэж байгаа. Яг энэ зүрх судасны төвтэй холбоотой энэ төсөл бол Монгол талаас Монголын Засгийн газраас бол хөрөнгө оруулалт байхгүй. 2 их санхүүжилтээр хийгдэнэ. Бас энэ 3 дугаар эмнэлгийн хамт олон, мөн Люксембург төслийг авч явж байгаа эмч нар бас их хичээл зүтгэлтэй, олон жил ажилласны үр дүнд ер нь зүрх судасны том төрөлжсөн мэргэжлийн төв байх нь чухал гэж Люксембургийн вант улсаас дэмжиж, тал мөнгө буюу 26,4 сая долларын буцалтгүй тусламжаар Люксембургийн Вант улсаас өгнө. Нийтдээ 15,646м², 119 ор бүхий эмнэлэгт 34,9 сая ам.доллар хөнгөлөлттэй ийм зээлийг Европын сэргээн босголтын банкнаас авах гэж байгаа юм. Тэгэхээр энэ хэлэлцээр бас их амжилттай сайн хийгдсэн хэлэлцээр гэж бас үзэж байна.

Р.Сэддорж: Батболд гишүүн тодруулж асууна.

Р.Батболд: Хэдэн хувьдаа тоног төхөөрөмж, хэдэн хувьдаа барилга байгууламж байгаа вэ гээд.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр нийт төсөл маань бол 60 давсан сая долларын зээл байгаа. Үүний 34,9 сая нь бол барилгадаа, 26,4 нь буцалтгүй тусламж нь тоног төхөөрөмждөө байгаа. Тэгээд тооцоолоод яг хувилаад бодохлоор 51, 52% нь байшин барилгадаа орж байгаа.

Р.Сэддорж: Батболд гишүүн 1 минут.

Р.Батболд: Зээлийн хэлэлцээрийг бол дэмжиж байгаа. Тэгээд би энэ нөгөө төсөвтэй холбоотой асуудал ороод ирэхээр л ярьдаг нэг юмтай болчихоод байгаа юм. Гадаад зээл тусламжийнхаа энэ ашиглалтыг нь сайжруулаад үр өгөөжтэй байлгаач ээ гэдэг тал дээр л их санаа зовоод байгаа юм. Энэ гаднын байгууллагаар юм хийлгэхээр дандаа төсөвт өртөг нь өндөр байгаад байдаг. Дотоодын аж ахуйн нэгжүүдийн хийж бүтээж байгаа барилга байгууламжийн өртөг нь ч гэх юм уу жишээлбэл өндөр байгаад байдаг. Эмнэлгийн хувьд бол ойлгож байна. Энэ тусгай хэрэгцээтэй юм уу, тусгай тоног төхөөрөмж байрлах өрөөнүүдийн гээд мэдээж шаардлага нь өөр байх байх. Тэгэхдээ энэ төсөвт өртөг дээр нь бас сайн анхаарч ажиллаарай л гэж хэлье. Ер нь бол энэ зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Батболд гишүүнд баярлалаа дэмжиж байгаад. Ер нь бол эмнэлгийн барилга бол үнэхээр өвөрмөц онцлогтой байдаг. Ялангуяа 8 хагалгааны өрөөтэй, дээрээс нь шигдээс харвалттай холбоотой Ангиокатлаб гэж нэрлэдэг ийм тусгай зориулалтын, дээрээс нь дэд бүтэц нь, агааржуулалт нь, урсгал нь. Тэгээд төслийг Монгол талаас хариуцахгүй. Энийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк буцалтгүй тусламж 800 мянган ам.доллараар төслийн багийг санхүүжүүлж, тэгээд Люксембургийн вант улсаас төслийг нь удирдаж гүйцэтгүүлэхээр тохирсон байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Зүрх судасны үндэсний төв байгуулахыг дэмжихгүй гээд яах вэ дээ. Ер нь бол их өрөвдөлтэй байгаа байхгүй юу. Бүхэл бүтэн улс байж гадаадын зээлээр энийг хэрэгжүүлнэ гэдэг чинь маш тийм ичмээр байгаа байхгүй юу. Энэ чинь хүний хөгжлийн хамгийн чухал зүйл бол эрүүл мэнд буюу дундаж наслалт, тэгээд боловсрол, тэгээд айл өрхийн орлого л байгаа шүү дээ. Тэгээд энийг бол 100 хувь дэмжих ёстой. Харин надад хэдэн асуулт байна.

1 дүгээрт энэ зөвхөн барилгад зээл зарцуулагдах уу. Эмч нарыг буюу хүний нөөцийг дэмжихэд зориулж энэ дээр хэдэн төгрөг зарцуулагдах вэ. Энэ хамгийн чухал зүйл шүү. Ер нь бол ус, агаар мэт хамгийн хэрэгтэй хүн бол профессор, эмч нар. Тэгээд энэ хүн ур чадварыг эзэмшихийн тулд өөрийн ухамсарт амьдралаа бүгдийг нь зориулсан байгаа шүү дээ. Тэгээд харамсалтай нь энэ хүн дээр маш их механик ачаалал өгдөг. Тэгээд хараад байхад эмнэлэгт эмч нар ингээд л бүх өөрийнхөө тэр өвчний түүхийг бичнэ. Тэгээд хайран цагаа механик ажиллагаанд зарцуулаад байна гэж би бол хөндлөнгөөс дүгнэдэг. Тийм учраас эмч нарыг сургахад, гадаад оронд мэргэжил дээшлүүлэхэд байнгын орчин үеийн ямар эмчилгээний арга тактикууд олон улсын хэмжээнд, өндөр хөгжилтэй орнуудад нэвтэрч байгаа юм бэ. Энийг ер нь яг яаж энэ хүмүүсээ тогтмол энэ үйл ажиллагаанд, энэ сургалтад, зөвлөгөөнд, гадаад дотоодод болж байгаа арга хэмжээнд ер нь хамруулах вэ. Энд ямар зардал төлөвлөж байгаа вэ. 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ төв байгуулагдсанаараа эмч нарын механик ажлыг багасгахын тулд сувилагч, бусад ажилтнуудын ц хүртээмжийг ер нь нэмэх үү. Тэгэхгүй бол маш сайхан барилга, маш сайхан тоног төхөөрөмжтэй боллоо ч гэсэн энэ маань энэ асуудал үүсэх вий.

2-т нь энэ нисдэг тэрэгний үйлчилгээ орон нутгуудад нэвтрүүлэх үү. Энэ зээлээс энэ дээр ер нь хөрөнгө гаргах уу. Аймгуудаас 20, 30 сая төгрөгөөр харвалт өгсөн хүмүүсийг ар гэр нь арай ядан өр зээл хийн барин тээвэрлэж авчирч байгаа шүү дээ. Тэгээд энэ бол цогц үйл ажиллагаа. Энэ өргөн уудам нутагтай Монгол Улсын хувьд бол энэ анхаарахаас өөр аргагүй. Сайхан төв байгуулаад ч гэсэн хөдөөгөөс хүмүүс Баян-Өлгий аймгаас, Дорнодоос ирж чадахгүй бол яах вэ. Тэгэхээр энийг ер нь цогцоор нь авч үзэж байгаа юу. Энэ дээр дахиад нэмэлт хөрөнгө шаардлагатай юу. Энийг шийдэж байж ийм цогцоор их том төсөл болно гэж би бол харж байгаа. Би чинь хамгийн зүүн захын аймагт ажиллаж байсан болохоор энэ зовлонг бол маш сайн мэдээд байгаа юм.

Урьдчилан сэргийлэх ажил руу эндээс хөрөнгө зарцуулах уу. Ер нь зүрх судасны өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан, дараагийнх нь хоол боловсруулах шалтгаан байгаа. Хүүхдийн өвчлөл байгаа. Тэгээд энэ рүү чиглэсэн дараагийн нас баралтын шалтгаанууд болсон эрэмбээрээ 2, 3-д байгаа энэ рүү чиглэсэн ... /минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт Чинбүрэн сайд. Холбогдох хүмүүс дараа нь нэмж хариулаарай. Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Бадамсүрэн гишүүн зөв яг цогцоор нь юмыг харж байна. Баярлалаа. Тэгэхээр эхлээд бол энэ барилга зүрх судасны мэргэжлийн төв болно гэдэг маань энэ нэг тусдаа том төсөл. Үүний араас бид бас Азийн хөгжлийн банкаар түргэн тусламж, харвалт шигдээс аймаг бүрд тусалж чаддаг тогтолцооны дараагийн төсөл бас та бүхэнд танилцуулагдана. Тэгэхээр бүх юм хоорондоо уялдаатай. Бид нэгэнт гаднаас зээл аваад хийх гэж байгаа бол хоорондоо уялдаатай, нягт холбоотой ийм ажил хийхээс баахан салангид утга учиргүй баахан зүйл хийгээд, хэдэн төсөл санхүүжүүлдэг байх ёсгүй гэдэг байр суурьтай Эрүүл мэндийн яам энэ 2026 оны хөрөнгө оруулалт дээр онцгой анхаарч ажиллаж байгаа. Тэгэхлээр Улсын гуравдугаар төв эмнэлгийн бас зүрх судасны салбар бол 24 жилийн турш Люксембургийн Вант улстай хамтран ажиллаж, хүний нөөцийн бэлтгэл ажлыг хангалттай хийж чадсан. 24 жил ажиллахдаа зүрх судасны мэргэжлийн баг бүрдүүлэхээс гадна, 21 аймаг, дүүргүүдэд хамтарч ажилладаг цахим хүртэл систем бий болгочихсон. Тэнд харвасан шигдээс болсон өвчтөнийг шилжүүлэх, авах тогтолцоог хийж чаддаг ийм тогтолцоотой болчихсон. Тэгэхээр одоо тусгай мэргэжлийн төвтэй болж, энийг хэрэгжүүлэх нь өөрөө цаг хугацааны шаардлага болсон. Үүнийг ч гэсэн Люксембургийн Вант улс бас онцгой анхааран харж, буцалтгүй тусламжаар тоног төхөөрөмжийг нь санхүүжүүлж байна.

Нийтдээ 8 давхар 15079м², 119 ортой, 80 энгийн, 16 эмчилгээний, 15 эрчимт эмчилгээний, 8 өдрийн, мэс заслын 8 өрөө. Энд бол зөвхөн шигдээс харвалтыг менежмент хийхээс гадна, зүрх шилжүүлэн суулгах хагалгааг хүртэл Улсын гуравдугаар төв эмнэлэг хийхээр энд бас төлөвлөж байгаа гэж харж байгаа. Тийм учраас энэ бол ер нь хамгийн хүндэрсэн, шийдэж чадахгүй байгаа төвөгтэй тохиолдлууд бүрийг Улаанбаатар хотод авчирч эмчлэх боломжтой болно. Энэ дээр харин нисдэг тэрэгний асуудал орсныг Төмөр-Очир захирал хариулаад өгөөч. 4 номерын микрофон дээр.

Р.Сэддорж: Нэмж хариулъя. 4 номер.

Ц.Төмөр-Очир: Баярлалаа. Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Төмөр-Очир. Ингээд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны удирдлага, бүрэлдэхүүнд өнөөдөр энэ асуудлыг авч хэлэлцэж байгаад талархал дэвшүүлье. Тэгэхээр 5 шатны 25 жилийн хугацааны төсөл ингээд тасралтгүй буцалтгүй тусламжаар хэрэгжсэн нь хамгийн гол нь Монгол улсын зүрх судасны тусламж, үйлчилгээг сайжруулах, бэхжүүлэх, үндэсний хэмжээний зүрх судасны төвийг барьж байгуулах хэмжээнд хүргэх бүх нөөцийн чадавхыг бол бас бүрдүүлсэн байгаа. Тэр түвшинд бол ерөнхийдөө Монгол Улсын эрүүл мэндийн салбарт зүрх судасны үндэсний сүлжээ, тогтолцоо бий болсон. Эрүүл мэндийн салбарын хамгийн анхны зай оношилгооны цахим программыг нэвтрүүлээд өнөөг хүртэл хөдөө орон нутгаас шаардлагагүй шилжилт хийдгийг 56 орчим хувьд бууруулаад, нгээд шууд/минут дуусав/

Р.Сэддорж: 4 номер нэмж хариулъя.

Ц.Төмөр-Очир: Тэлмэзийн сүлжээгээр бол энэ орон нутагтайгаа харьцаж байгаа юм. Тэгэхээр сая сайд хэлсэн байгаа. Сургалтын чиглэл дээр 24 жилийн хугацааны төсөл бол чадавх бүрдүүлэх түвшинд 3 дугаар эмнэлэг төдийгүй 21 аймаг, 9 дүүргийн эмч мэргэжилтнүүдийг тасралтгүй чадавхжуулж байна. Нөгөө

талаараа 22,5 саяын буцалтгүй тусламж Мон-008 төсөл дээр бас эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах үйл ажиллагааны төлөвлөлтүүд бол орсон байж байгаа. Ингээд удахгүй Люксембургийн Засгийн газар батлаад, манай Засгийн газарт ирүүлнэ гэдгээ бол илэрхийлээд, энийг бас Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдад мэдэгдсэн байж байгаа. Нөгөө талаараа бол Мон-009 гээд дахиад 5,5 сая долларын буцалтгүй тусламжийн төсөл бас энэ жил багтаж Засгийн газартай гэрээ байгуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Энэ Мон-009 нь бол эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах төсөл байгаад байгаа.

Р.Сэддорж: 4 номер дахиад 1 минутад тодорхой товч хариулъя. Нисдэг тэрэгний талаар.

Ц.Төмөр-Очир: Нисдэг тэрэг бол ерөнхийдөө Гэмтэл согогийн үндэсний төв дээр нисдэг тэрэгний талбай байгаа учраас байршлын хувьд бол шууд 3 дугаар эмнэлэг хуваалцаж ашиглана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Урьд нь бид бас гэмтэл дээр онгоц буулгаад зүрхний, тархины харвалттай хэд хэдэн тохиолдлыг бас орон нутгаас шилжүүлэг хийж авсан байж байгаа. Тэгэхээр зардлын хувьд бол яг тэр талбайгаа ашиглаад, хэмнэлт гаргах боломжтой гэж тооцоолсон байгаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Би ингэж асуугаад байгаа юм. Онцгой байдал нисдэг тэрэгний төсөл хэрэгжүүлсэн Францын дэмжлэг тусламжаар. Тэр шиг эрүүл мэндийн салбар өөрөө нисдэг тэрэггүй шүү дээ. Тэгээд онцгой байдал юм уу, өөр газраас иргэд хүсэлтээ тавьж байж авчирдаг байхгүй юу. Тэгээд энийг яаж цогцоор нь шийдэх юм бэ л гээд байгаа юм. Орон нутагт өндөр зэрэглэлийн хагалгааг хийж чадахгүй. Тэгэхээр энийг Улаанбаатарт хийнэ гэхээр чинь хамгийн чухал зүйл чинь цаг шүү дээ. Цаг алдахгүй тээвэрлэж авчрах ёстой байхгүй юу. Тэгэхээр би юу гэж хэлээд байна гэхээр зөвхөн нийслэлийн хэмжээнд биш орон нутгийн хэмжээнд хараач ээ. Тэгээд болдог бол санал, дүгнэлт дээрээ энийг шийдэх нь зүйтэй гэдгийг Засгийн газарт Байнгын хороо чиглэл болгож өгөх хэрэгтэй гэж би хэлж байгаа юм. Тэгэхгүй бол Эрүүл мэндийн сайд Чинбүрэн сайд өөрөө санаачлаад оруулж ирээд хөөцөлдөөд яваад, тэгээд тэрийг нь дэмжсэн болоод орхиж болохгүй. Дээрээс нь нэмээд энэ зүйлийг цогцоор нь шийдэх хэрэгтэй.

2 дугаарт нь энэ урсгал зардлыг яаж тооцож байгаа вэ. Нэмэгдэл юмыг эртнээс төсөв дээрээ ингэж яаж бодож..../минут дуусав/

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Ер нь эрүүл мэндийн салбарт, ялангуяа энэ түргэн тусламжийн үйлчилгээ нисдэг тэрэгний тусламж үйлчилгээг оруулах асуудал бол онцгой чухал. Гэхдээ бид бас нөгөө илүү үр дүнтэй тогтолцоо руу оръё гэх юм бол Онцгой байдалтайгаа хамтраад ажиллахаас л өөр арга байхгүй. Тэгэхээр ингэж ажиллаж байгаа. Ер нь жишээлбэл Эрүүл мэндийн яамнаас Онцгой байдал хүсэлт гаргаад, яаралтай хүмүүсээ тээвэрлэсэн хэвээр байгаа. Харин аажимдаа бид энэ санхүүжилтийн улс орны эдийн засаг гайгүй болоод ирэхлээрээ энийг нь даатгалаас даадаг байх тогтолцоо руу аажим шилжинэ. Одоо дараагийн АХБ-ны төсөл дээр бас энэ нисдэг тэрэг нэмэх асуудал Онцгой байдлын төсөл орж ирнэ. Энэ дээр бас онгоцоо нэмж байгаа. Ер нь онгоцны сервис өөрөө их өртөг ихтэй юм байна лээ. Тийм учраас Эрүүл мэндийн яам дангаараа хийнэ гэвэл энэ өртгийг нь дийлэхгүй, ачаалал дэндүү их болно. Харин түрүүн хэлсэн аймаг бүрд энэ олонхыг хамарч

байгаа тусламжийг үзүүлдэг болдог тогтолцоог ирэх 2 жилд хийхээр дараагийн төсөлд та бүхэнд танилцуулагдана.

Р.Сэддорж: Тэгээд Эрүүл мэндийн яам нисдэг тэрэг эд нар ярьдаг байхгүй бол бас болохгүй шүү ер нь бол. Ганц Онцгой байдалд найдаад. Тэгээд 20 сая төгрөг билүү, 22 сая төгрөг хийж байж тэр бензин тосных нь мөнгө байдаг юм уу, юуных нь зардал байдаг юм. Тэгээд л 1 юм хөдөө орон нутгаас, 600км-ээс хүн авчирдаг юм. 500км-ээс. Тэгээд энэ яг бодитой нөхцөл байдал. Тэгэхдээ яам яаралтай түргэн тусламжийн энэ нисдэг тэргээ 1-2-ыг яаралтай шийдээд явбал зардал бол лав л хямдарна даа. Дараагийн гишүүн Улсын Их Хурлын гишүүн Тулга.

Б.Тулга: Байнгын хороодын гишүүдийн өнөөдрийн амар амгаланг эрье. Энэ зээлийн хэлэлцээрийг бэлэн болгож ажиллана гэдэг бол бас амаргүй урт хугацаа шаардсан. Ялангуяа энэ төслийн бас тодорхой хэмжээ нь бол нэлээдгүй хэмжээ нь бас тусламжаар орж ирж байгаа юм байна. Тийм учраас энэ төслийг бол дэмжих нь зүйтэй гэдэг зарчмын байр суурьтай байна.

Тодруулж асуух ганц 2 зүйл байна. 2017 оны ТЭЗҮ, зураг төслөөр хийгдэж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр цаашдаа энэ ТЭЗҮ, зураг төсөл маань энэ чинь бараг 10-аад жил болох гэж байна гэсэн үг. Энэ барилга байгууламжийн бүтээн байгуулалт явах явцад өсөх ийм эрсдэл байгаа юу. Энийг бүрэн тооцсон уу гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

Мөн энэ төсөл маань өнөөдөр ингээд Их Хурлаар ороод, энэ оны төсөвт багтаад суугаад явах юм бол хэзээ эхлээд, хэзээ бүрэн ашиглалтад орохоор төлөвлөж байгаа вэ гэдэг тал дээр бас тодруулаад хэлээд өгөөч гэж хүсэж байна.

3 дахь асуулт бол энэ эмнэлгийн менежментийн асуудал 3 дугаар эмнэлгийг өргөтгөх маягаар явах гэж байна уу, аль эсвэл тусдаа бие даасан эмнэлгийн статустайгаар цаашид үйл ажиллагаа явуулах гэж байгаа юу. Энэ тал дээр бас мэдээлэл өгөөч.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тулга гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр төсөл 2026 онд эхлээд, 2032 онд дуусна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Барилгын ТЭЗҮ болон барилгын зураг бол нэлээн их өндөр хэмжээнд хийгдсэн. Төсөвт өртөгт нэг их өөрчлөлт мэдээж гарахгүй байх. Гэхдээ нөгөө төсвөө тооцохдоо мистиленис буюу нэмэгдэх, хасагдах зардал бол угаасаа орчихсон байдаг. Нэмэх, хасах зүйлүүд байгаа.

Барилга бол Улсын гуравдугаарт төв эмнэлгийн хашаа дотор тусдаа барилга болж баригдана. Барилгын урт нь 66 метр, өргөн нь 23,5 метр ийм тусдаа барилга. Тэгэхдээ эмнэлэг 1 удирдлага дор л ажиллана. 3 дугаар эмнэлгийн нэг хэсэг болж ажиллах нь гэж бол тооцно.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Зүрх судасны төв байгуулах энэ бол маш чухал ажил. Бидэнд ирүүлсэн мэдээлэл дээр олон тодорхой статистикууд байна лээ. Зүрх судасны өвчлөл харьцангуй залуужсан. Ялангуяа энэ өвчлөлөөр улсын хэмжээнд өвдөж байгаа иргэдийн дийлэнх олонх нь 3 дугаар төв эмнэлэг дээр эмчлэгдэж байна. Ачаалал маш өндөр байна. Энэ чиглэлийн

мэргэжлийн боловсон хүчнийг дадлагажуулах бааз суурь нь өөрөө энэ улсын 3 дугаар эмнэлэг болчихсон байна л даа. Тэгээд би бол 3 дугаар эмнэлгийнхэндээ бас баярлалаа гэж хэлмээр байгаа юм. Яг энэ зүрх судасны өвчлөлийн чиглэлээр бол Монгол Улсад ачааны хүндийг үүрч байна шүү дээ. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа асуудлыг дэмжиж байгаа. Энэ олон жил яригдсан асуудал. Өмнө нь бас энэ талаар яригдаж байсныг би бол мэднэ.

Харин энэ зээлийн хэлэлцээртэй холбоотой асуудалд надад Сангийн яамнаас асуумаар хэд хэдэн асуулт байна. Үнэхээр тулгамдсан асуудлуудаа бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаараа ядаж нэг эрүүл мэнд, боловсролын асуудлаа шийдэж чадахгүй зээлээр хийж байгаа нь харамсалтай. Гэхдээ одоо яах билээ. Чадахгүйгээс хойш, улсын төсөв дээр ачааллыг нь дийлэхгүйгээс хойш тэгээд зээлээд л явахаас. Гэхдээ зээлийн хэлэлцээрээ бид нар нөгөө гуйна гэдэг гутамшиг, гуйлгана гэдэг гайхамшиг гэдэг жишгээр хийж болохгүй л дээ. Тэгэхээр би Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам энэ хэлэлцээрүүд дээр нэлээн тооцоолол хийдэг байх ёстой гэж зарчмын байр суурь илэрхийлээд байгаа юм. Ялангуяа энэ гишүүдэд тарааж орж ирж байгаа материал дээр 1 дүгээрт зээлийн нөхцөл, түүнд энэ санхүүжилтийг авахад зарцуулж байгаа тэр санхүүгийн зардлуудыг нэг бүрчлэн та нар хүснэгтлээд оруулж ирж болдоггүй юм уу.

Одоо би хэлэлцээрээс 2, 3 асуулт асууя. Тухайлбал, зээлийн хүүгийн хэмжээг банкнаас тогтоосон шийдвэр бүр нь зээлдэгчийн эцсийн шийдвэрлэх, заавал биелүүлэх шинжтэй байна гэж байгаа юм. Тэгээд энийг юу гэж ойлгох вэ. Хүүг банк тухай бүрдээ өөрчлөөд байх эрхтэй. Тэрийг нь бид тэр бүрд нь хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм уу.

2-т нь мөн энэ дээр орж ирж байгаа юм. Банканд үүргийн шимтгэлийг зээлийн хэлэлцээрт заасан хувиар төлнө гэж байгаа юм. Энэ үүргийн шимтгэлийн хэмжээ нь зээлийн хэлэлцээрт заасан нөхцөлөөсөө нөхцөлт бус байх юм бол 0,5%-аар нэмэгдэнэ гэж байгаа юм. Мөн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж 0,5% гээд байгаа юм. Зээлээ бид нар хугацаанаас нь өмнө төлөх юм бол бас хүү төлөх юм байна лээ. Үлдэгдэл дүндээ. Гэх мэтчилэн энэ зээлтэй холбоотой гарч байгаа санхүүгийн зардлыг 1 хүснэгт дээр, 1 хавтгай дээр та нар харуулж өгөөч. Зээлийн хүүтэйгээ нийлээд ямар хэмжээний өртөгтэй мөнгө бид нар худалдаж авч энэ эмнэлгээ барьж байгаа юм бэ гэдэг тодорхой ойлголттой болмоор байна.

Р.Сэддорж: 2 номер. Өөрийгөө танилцуулаарай.

С.Тулга: Сангийн яам Тулга. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Зээлийн нөхцөлийн хувьд бол 18 жилийн хугацаатай, 4 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөхөөр байгаа. Тэр гэрээ дээр байгаа хүүгийн нөхцөлийг тухай бүр гэдэг нь болохоор энэ хөвөгч хүүтэй зээл байгаа. Өөрөөр хэлбэл софер дээр нэмэх нь 1,6 хувь гээд, яг одоо софер хэд байна тэр дээр 1,6 хувийг нэмсэн ийм хэмжээтэй байна гэсэн үг. Одоогоор бол энэ бол 5,78 хувийн хүүтэй байгаа. 1 удаагийн үйлчилгээний шимтгэл 1 хувийг ер нь бол бүх IPRD нөхцөлтэй зээлүүд дээр бол зээлдэгч тал нь төлдөг. Энэ бол нийтлэг жишиг байгаа. Тэгээд тэр нөөцлөн баталгаажуулсны төлбөр 0,5 хувь гэдэг маань энэ нөхцөлтэй зээл маань ерөнхийдөө бол бас тодорхой хэмжээний хөнгөлөлттэй нөхцөлөөр орж ирж байгаа. 18 жилийн хугацаатай, 5,78 хувийн хүүтэй гэдэг маань ерөнхийдөө бол хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл байгаа. Энэ хэмжээний зээлийг Монгол Улс авна шүү гэдэг зээлийн амлалтаа гаргасан тул одоо энийгээ ашиглагдаагүй байгаа үлдэгдэл дээрээ энэ хэмжээний төлбөрийг Монгол Улс төлөхөөр хүлээсэн байгаа. Яагаад гэвэл энэ

хэмжээний эх үүсвэрийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк маань Монгол Улсад зориулж хадгалаад, бусад зээл хүссэн байгууллагад өгөхгүй, Монгол Улсад хадгалж байгаагийн төлбөр гэж энийг ойлгож байгаа. Яагаад энэ зээлээр санхүүжүүлж байна. Улсын төсвөөр санхүүжүүлэхгүй байна гэдэг асуудал маань бас нөгөө талтай. Бид бол нийгмийн шинж чанартай энэ төслийг бол ерөнхийдөө хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа. Энэ 26,4 сая долларын буцалтгүй тусламжийг нэмэхээр манай өрийн удирдлагын хуульд зааснаар энэ төслийн нийт блендэд эх үүсвэр маань хөнгөлөлттэй болж хувирч байгаа юм. Тэрнээс гадна Люксембургийн Их гүнт улсаас орж ирж байгаа энэ буцалтгүй тусламжийг дагаад, яг энэ зүрх судасны чиглэлийн ноу хау орж ирж байгаа Монгол Улсад. Тэгээд үүгээрээ бас онцлогтой гэж бид дүгнэж байгаа.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Хөвөгч хүүг ойлгож байгаа. Хөвөгч хүү бол тухайн үеийн софер ямар хувьтай байгаагаас хамаараад л тухайн үедээ тогтоод л явдаг шүү дээ. Тэрийг манай авч байгаа банк тогтоохгүй байхгүй юу. Та нар энэ заалтаа уншаад үз л дээ. Хөвөгч хүүгийн тухай асуудал заалт биш байна шүү дээ. Наад заалт чинь. Тийм учраас Байнгын хорооны дарга аа, надад минут бага учраас санал байна. Хүсэлт тавимаар байна. Энэ зээлийн хэлэлцээртэй холбоотой санхүүгийн зардлуудыг зээлийн хүүтэй нь, тооцоололтой нь хамт 1 хавтгай дээр гаргаж танилцуулаач ээ. Бид жилд ямар зардал гаргах юм. Энэ зээлийг авахдаа ямар зардал төлөх юм. Тэгэхгүй бол энэ тайлбарлаж байгаа 1 хувиас чинь гадна, дахиад үлдсэн мөнгөн дээрээ нөхцөлд нь тодорхой бус бол дахиад 0,5 хувиар нэмэгдэнэ гэдэг заалт яваад байна шүү дээ. Та хэд энэ нөхцөлийнхөө зүйл, заалтыг хар л даа. 3.05 дахь хэсэг дээр үүргийн шимтгэл ба зээл олгосны шимтгэл. Зээл олгосны шимтгэлээс чинь гадна үүргийн шимтгэл чинь 0,5 хувиар өсөх заалт яваад байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүдээ бүр тодорхой болгож .../минут дуусав/

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүний энэ шаардлагатай мэдээллийг цаасаар, яг тодорхой болгож ирүүлэх нь байна. Тэгээд Үүрийнтуяа гишүүн болон наашаа ажлын албанд бас өгчих. Тэгээд манай Байнгын хороогоор дэмжих эсэх нь шийдэгдээд, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орно. Тэр дээр бас гишүүд асуудлыг асууж, тэмдэглүүлж болно. Санал гаргаж болно. Улсын Их Хурлын гишүүн Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Зүрх судасны үндэсний төв байгуулагдах юм байна. 2029 онд манай сайд байгаа. 2032 онд. 2025-2029 онд гэсэн юм л уншсан санагдаад байх юм. Тэгээд 119 ортой юм байна. Мэс заслын 8 өрөөтэй юм байна. Тэгээд 34,9 сая долларыгоо төгрөг рүү шилжүүлбэл 121,2 тэрбумаар баригдаад, дээр нь 94,7 тэрбумаар тоног төхөөрөмж буцалтгүй тусламжаар орж ирээд, тэгээд одоо бас Люксембургийн Гүнт улсаас тусламжаар тоног төхөөрөмжүүд орж ирчихсэн. Тэрийг нь тохирохыг нь шилжүүлнэ гээд ингээд явж байгаа юм байна. Одоо бол Софер хүү 4,18-тай гээд 1,6-г нэмбэл 5,78 хувьтай. Ингээд яваад байхаар эргээд хэдэн төгрөг улсын төсөв дээр, урсгал зардал дээр тавигдах юм гэдгийг нь харж үзье. Тэгээд тэгээд энэ мэдээллийг бодож үзэхэд би энийг асуух гээд байгаа юм. Сангийн яамнаас яг энэ төсөөлөл зөв байна уу гэдгийг нь асууна шүү. Эхний 4 жилдээ бид нар бол үндсэн дээлээсээ төлөлт явахгүй. Монголд мөнгөөр 7,2 тэрбум төгрөгийг одоогийн ханшаар жил болгон өгөх юм шиг байгаа юм. Тэгэхээр 2027 оны төсөв дээр урсгал зардал энэ төсөлтэй холбоотойгоор 7,2 тэрбумаар нэмэгдэх юм байна. 5 дахь жилээсээ авхуулаад үндсэн зээлийн төлбөртэйгөө яваад оронгуут 17,2 тэрбум төгрөг бид нар төлөх юм байна. Тэгэхээр Монгол Улсад ер нь мөнгө

байгаа юм биш үү. 119 ортой эмнэлгийн барилга барих гэж бид нар 121 тэрбум төгрөгийг гаднаас зээлээд, дээр нь буцалтгүй тусламжаар 94 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж аваад, 119 ортой шүү дээ тэ. Тэгээд буцаж жил болгон бид нар ирэх жилээс авхуулаад урсгал зардлаа 7,2 тэрбумаар тэлэх гэж байна шүү дээ манайхан. Урсгал зардал дээрээ тавигдахгүй тэгээд өөр хаана тавигддаг юм. Тэр мэдээллээ та хэд өгөх хэрэгтэй шүү дээ. Зээлийн эргэн төлөлтөөрөө харагддаг юм болов уу. Тэгээд 2017 оны техник-эдийн засгийн үнэлгээ гээд байгаа юм. Тэгэхээр энэ их бид нарт байгаа ирэх жилээс 7,2 тэрбумыг буцааж өгөх гэж байгаа юм бол энэ мөнгөө эмч нарынхаа цалин эд нар дээр оруулах ёстой шүү. Би тэгж 1 их попроод байдаг хүн биш л дээ. Гэхдээ л хөдөө орон нутгаар явахаар эмч нарын, багш нарын цалин бага байгаа нь үнэн шүү дээ. Бид нар үнэхээр л мөнгөтэй байгаа юм бол тэр чиглэл рүүгээ хандуулсан нь дээр биш үү. Тэгээд би сайдаас уучлалт хүсэх гээд л байна л даа. Хангалттай мэдээлэл, үнэхээр шаардлагынх нь талаар мэдээлэл байхгүй байгаа үед гадаад зээлээ ингэж их тэлээд, ирэх жилүүдээс бид нар 7,2 тэрбум. Тэгээд 4 дэх, 5 дахь жилээсээ 17 тэрбумыг ингээд энэ зээлд өгөөд л явах нь байна л даа. Тэгээд энэ дээр эхлээд яг тооцоолол зөв байна уу. Сангийн яам хариулаад өгөх байх. Тэгээд дараа нь тодруулъя.

Р.Сэддорж: Сангийн яам тодорхой хариулаарай. 2 номер.

С.Тулга: Уянга гишүүний асуулт хариулъя. Энэ урсгал зардал дээр Уянга гишүүнээ хүүгийн төлбөр л орж байгаа. Үндсэн төлбөрийн эргэн төлөлт бол ерөнхийдөө урсгал зардалд ордоггүй. Хүүгийн төлбөр бол юу яая даа. Түрүүн бас Үүрийнтуяагийн гишүүн ярьж байна. Одоо яг жил болгоноор хэдий хэмжээний зардал урсгалаас гарах юм. Үндсэн төлбөр хэд байх юм гэдгийг бид нар хүснэгтлээд хүргүүлъя. Тэгэхдээ яг одоо хариулахад хүүгийн төлбөр бол жил болгон 1 сая орчим доллар эргэн төлөгдөх юм байна. Тэгээд энэ нь болохлоор нөгөө үүргийн гүйцэтгэлээрээ буураад, буураад явна. Эхний 8 жил бол хүүгийн төлбөр сая доллар төлөгдөнө. Тэгээд энэ нь буурч явсаар байгаад элэгдээд дуусах ийм хуваарьтай байгаа. Энэ мэдээллийг бас хүргүүлъя.

Ер нь бол энэ онд бид нар хүүгийн төлбөрт 1,2 их наяд байгаа. Ирэх жил 1,3 их наяд байна. Тэгээд ерөнхийдөө 2028 он хүртэл хүүгийн зардал бид нар 1,3 их наядын зардалд багтаана гэсэн ийм тооцоолол хүрээний мэдэгдэлтэй хамт хийсэн байгаа. Тэгэхээр хүүгийн төлбөр дээр бол Засгийн газар ингээд тогтвортой энийгээ хадгалаад явна. Энэ дээр юу нөлөөлж байна вэ гэхээр мэдээж валютын ханшийн нөлөөлөл нэмэгдэж байгаа. Тэрнээс бусдаар бол Засгийн газрын авч байгаа зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хүүгийн төлбөр бол ер нь бол тогтвортой явж байгаа сүүлийн жилүүдэд.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Уянга гишүүн ээ, бид бол бүгдээрээ салбар бүрдээ иргэдийнхээ цалин хөлсийг нэмэгдүүлэхийг бол чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Тэгэхдээ боломж байхгүй байна шүү дээ. Өнөө жил 2026 онд бид мөнгөтэй юм уу. Мөнгө байна уу. Байхгүй байгаад байгаа байхгүй юу. Өнөөдөр бид ард иргэдээсээ аль салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх вэ гээд асуухад эрүүл мэндийн салбарт гэсэн. Бидэнд олдож байгаа боломжтой, төсөв дээр санхүү хамгийн бага очих зардал бол ийм л юм байна.

Нөгөө талаасаа бид бас нэг зүйлийг ойлгох ёстой шүү. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр Засгийн газрын зардал ДНБ-ий 38 хувиас хэтэрч

болохгүй. Тэр дотроо урсгал зардал 24 хувиас их байж болохгүй. Тэгэхээр бид бас энэ дээр их олон зүйлийг бодох ёстой юм байна. Их Хурлын гишүүддээ, ялангуяа Эдийн засгийн байнгын хороонд би байгаа учраас та бүгдээс хүсэж байгаа зүйл бол бид энэ санхүүгийн бүртгэлийн аргаа, ялангуяа Эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн сан буюу иргэдээс хурааж авч байгаа..../минут дуусав/

Р.Сэддорж: Тодруулж асууя Уянга гишүүн.

Б.Уянга: Сангийн яамнаас тэр нэгдсэн хүснэгтийг хүлээж байя. 1 сая доллароос бол их гэж харагдаж байна лээ. Тэгээд 1 сая доллар гээд бид нарт хариулаад сууж байж болохгүй шүү дээ. Эхний зээлийн хүүдээ тэдийг өгнө гээд. Тэгээд тэрийгээ бас харъя. Тэгээд 2026 онд алдагдалтай төсөв батлагдах гэж төсөл орж ирснийг энд сууж байгаа бүх Улсын Их Хурлын гишүүд мэдэж байгаа. Тэгэхдээ 2027 оноос хэрвээ энэ зээл гарчих юм бол бид нар 2 сая доллар гээд л бодоод үзэхэд 7 тэрбум төгрөг бид нар төлөх байхгүй юу. Тэгэхээр одоо 2026 онд мөнгө байхгүй. 2027 оноос тэгвэл тэгээд эмч нарынхаа цалинг нэмчихье л дээ.

Үгүй ээ, тэгээд энэ чинь бид нарт мөнгө байгаад, буцаагаад мөнгө төлөх гээд байна шүү дээ. 7,2 тэрбум. Тэгээд би энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүдтэйгээ санал нийлэхгүй байж болно шүү дээ. Тэгээд яаж ч бодсон гэсэн зээл олдож байгаа дээр нь авчихъя гэдэг менталити бол буруу байх. Асуулт биш шүү.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр бид зээлээр бол мэдээж урсгал зардлаа нөхөөд, цалин хөлс нэмж болохгүй л дээ. Тэгэхээр миний түрүүн хэлдэг санаа бол бид аль болохоор бүртгэлийн журам дээрээ иргэдийн даатгалд өгч байгаа мөнгийг урсгал зардал дээрээ тооцдоггүй байх энэ тогтолцоог яаралтай хийхгүй л бол бид цалин хөлс нэмэх боломжоо нөгөө төсвийн хязгаараараа боогоод байгаа шүү дээ. Тэгэхдээ бас нэг ийм буруу ойлголт байхгүй. Би тэгэхдээ тэгж бодохгүй байна. Зүгээр нэг чухал асуудал бол бид мөнгө байгаад байхад нь ажилчдынхаа цалинг нэмэхгүй, баахан байшин сав барих гэж байгаа юм уу гэдэг ойлголт бас оччих вий. Тийм биш шүү. Мөнгө байхгүй байгаа учраас зээл тусламжаар хүмүүнлэг, нийгэмд хэрэгтэй зүйлийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг гаднын нэн хөнгөлөлттэй зээлүүдээр хийж байгаа гэдгийг бас зориуд энд тодотгож хэлье.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учир Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Би бас нэмээд 1 зүйлийг хэлэх хэрэгтэй байна. Одоо зээл аваад цалин нэмэх гээд байгаа асуудал ерөөсөө яриагүй байна. Хэрвээ зээлээ авчих юм бол ирэх жилүүдээс 2027 оноос бид нар зээлийнхээ хүүгийн төлөлтөд 7 тэрбум төгрөг төлөх гээд байна. Хаа нэгтэйгээс энэ мөнгө чинь гарч ирнэ шүү дээ. Нөгөө нүүрснээс л гарч ирэх байх даа. Тэгж л хэлээд байгаа юм.

Р.Сэддорж: Ирсэн ажлын хэсгийг танилцуулахад 1 хүн дутуу танилцуулсан байна. Пүрэвхатан Барилгын Хөгжлийн төвийн захирал.

Тулга гишүүн, Үүрийнтуяа гишүүдийн асуултад бас барилгын ТЭЗҮ, төсөвтэй холбоотойгоор нэмж тайлбарлаач. 6 номер.

Т.Пүрэвхатан: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ Зүрх судасны үндэсний төвийн барилгатай холбоотой 2020 онд 79,2 тэрбумаар, 2022 оны 10 сард төсөв шинэчлэгдээд Төсвийн тухай хуулийн 29².2-ын дагуу төсөв шинэчлэгдээд 92,3 тэрбум болж өөрчлөгдсөн. Одоо бол үүгээрээ явж байгаа. Энийг нь бол дунд нь салгаад үзэхэд түрүүн нөгөө Тулга гишүүн бас асуусан хэдэн оны ТЭЗҮ, төсөв юугаар явж байгаа вэ гэсэн. 2016 он биш энэ бол 2022 оныхоор явж байгаа. Тэгээд барилга угсралт дээр 70,5 тэрбум, тоног төхөөрөмж дээр 16,8 тэрбум, гадна шугам сүлжээ, тохижилт, зам талбай гэх мэтэд бол 6 тэрбум гээд явж байгаа. Тэгээд буцалтгүй тусламжаар бол тоног төхөөрөмжийн хувьд буцалтгүй тусламж. Тэр нь бол магадлалын нэгдсэн дүгнэлтэд ордоггүй ийм байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Бараг үдээс хойш болчихлоо доо. Оройны мэнд хүргэе. Энэ Зүрх судасны Үндэсний төв байгуулах төсөл бол ер нь бол судалгаануудыг хараад байхад хэрэгтэй, хамгийн чухал хэрэгтэй болчихоод байгаа юм. Ард иргэдийн хүсээд байгаа ч юм. Гэхдээ зүгээр энэ манай Улсын Их Хурлын гишүүдээс асуугаад байна. Сангийн яамтай холбоотой энэ тооцооллуудаа их зөв хийхгүй бол их л сонирхолтой л харагдаад байгаа юм. Яг өнөөдөр энэ баталгаат овер найт санхүүжилтийн хувьсах хувь софер чинь хэдэн хувийн хүүтэй байгаад байгаа юм. Та нар яг зээл авах үедээ ер нь хэд болох магадлалтай юм. Нэмэх нь 1,6 гэхэж байгаа юм. Дээрээс нь энэ хөрөнгө нөөцөлж баталгаажуулсны хураамж жилийн 0,5 хувь гэхэж байгаа юм. Тэгээд энийгээ яг тодорхой болгоод бид өнөөдөр 18 жилийн хугацаанд ийм хэмжээний зээл аваад, ийм хэмжээнийхээр эргэн төлөгдөнө гэж энэ Их Хурлын гишүүдэд мэдээлэлжүүлмээр байгаад байгаа юм. Тэгэхгүй ерөнхий юмнуудаа тавьчихаад ингээд ороод ирнэ. 1-д.

2-т гэх юм бол Чинбүрэн сайдаа, 2 материал дээр хоёулан дээр нь 2 өөр цаг хугацаатай. Түрүүн Уянга гишүүн бас төөрч байна шүү дээ. Энэ чинь 2025 онд эхлээд 29 онд дуусах ёстой ажлыг энэ материал дээр 2026 онд эхлээд 32 онд дуусгана гээд ингээд 2 өөр материал. Тэгээд энэ бид нарт тараасан нь энэ шүү дээ. Тэгэхээр энэ материалуудаа хүртэл та нар чинь ийм зөрүүтэй юм оруулж ирчхээд, тэгээд Их Хурлын гишүүдийг мэдээллээр бүрэн хангадаггүй. Одоо бид нар араас чинь ингэж хөөцөлдөж байж дараа нь дахиад өөр материал орж ирэх юм уу. Тэгээд энэ байдлаа юу гэж харж байгаа юм Чинбүрэн сайд аа.

Дараагийн асуулт хэдий хугацаанд ер нь судлагдаад, ямар нэгж байгуулагдаад явсан юм бэ. Ер нь цаашдаа энэ зээл чинь дотоодын барилгын компаниуд, дотоодын энэ ажиллах хүчийг дэмжих юм уу, дэмжихгүй явах юм уу. Энэ дээр одоо Сангийн яам ч байдаг юм уу, Эрүүл мэндийн сайд бас хариулаад өгчихвөл зүгээр байгаа. Тэгээд үндсэн 3 асуултад хариултаа авчихаад тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт 2 номер.

С.Тулга: Сангийн яам Тулга. Гишүүний асуултад хариулъя. Софер бол одоо 4,2 хувьтай байгаа. Энэ ингээд хөвөгч хүү учраас Америкийн холбооны нөөцийн хүү хэдээр тогтоно, түүнтэй уялдаж өсөж буурдаг одоо ийм хүү байгаа. Энэ бол цаашаа ерөнхийдөө буурах хандлагатай гэсэн ийм мэдээллийг бол Америкийн Холбооны нөөцөөс мэдэгдсэн байгаа. Тэгээд бид нар одоо байгаа хүүгийн түвшинд тооцох юм бол тэгээд зээлийн ашиглалт бүрэн гарсан тохиолдолд нийт гарсан зээлийн ашиглалт буюу энэ 34,5 сая долларын бүрэн гарсан тохиолдолд 2 сая ам.долларын зээлийн хүү жил бүр төлөх юм байна гэсэн ийм тооцооллыг ерөнхийдөө

танилцуулгад оруулсан байгаа. Тэгэхээр зээлээ хэдий хэр ашиглана, төдий хэмжээгээр ерөнхийдөө хүүд ороод явна гэсэн үг. Хүү тооцогдоод явна гэсэн үг. Бид нар ашигласан дүн дээр л зөвхөн хүү төлдөг байгаа. Ашиглаагүй дүн дээр бол хүү төлөхгүй. Ашиглаагүй дүн дээр бид нар нөгөө хөрөнгө баталгаажуулсан төлбөр буюу жилийн 0,5 хувь ийм шимтгэл төлдөг байгаа.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр түрүүн хэлсэн төслийн нэгж бол үндсэндээ Люксембургийн Вант улстай бүтэн 24 жил хамтарч ажиллаад, хүний нөөц бэлтгэх, Монгол улсад зүрх судасны өвчлөлийн нөхцөл байдал, тэдгээрийг эмчлэх энэ бүх боломжууд нь бол нэлээн сайн бүрдсэн байна гэдэг үндэслэл дээр төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг барья гэж тохирсон. Тэгээд төсөл маань бол 2026-2032 он. Энэ сүүлд өгсөн материал бол 2026-2032 онд баригдаж дуусна. Ер нь энэ их том цогцолбор. Тэгэхдээ энэ 2029 оны төгсгөлд бол ер нь барилгын ажлаа дуусгаад, тэгээд үргэлжлүүлээд нөгөө тохируулах, Монголд нутагших, боловсон хүчнийг нь бэлдэж дуусгах, төслийг бүрэн хүлээлгэж өгөх гэдэг хугацаагаа 2023. Тийм учраас 2029/минут дуусав/

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулж асууна.

Г.Очирбат: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр бас орж ирэх юм байна лээ. Тэгэхээр эд нарыгаа яг мэдээллээ нэгтгэчхээрэй. 1 дүгээрт. Тэгэх юм бол бид нар бас уншиж танилцаад асуух асуултууд, бусад тэр мэргэжлийн байгууллагуудтай асуултуудаа бэлдэж орж ирэх гэж байтал яг Байнгын хорооны хурал эхлэнгүүт нэг өөр материал тараачихдаг. Тэгээд ингээд 2, 3 чиглэл рүү гишүүдийг татаад байвал шийдвэр гаргахад их төвөгтэй болно Чинбүрэн сайд аа. Дараа нь энэ дээр бас анхаарч ажиллаарай гэж хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Батжаргалын Заяабал гишүүн.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр би энэ тараагдсан материалтай холбоотойгоор бас хэдэн зүйл асууя гэж бодож байгаа юм. Энэ тараагдсан материал дээр хэлж байгаагаар нас баралтын тоогоороо зүрх судасны өвчин Монголдоо тэргүүлдэг. Монголын хүн амын 75 хувь нь зүрх судасны өвчлөлийн эрсдэлтэй гэж бичсэн байгаа юм. Ингээд 75 хувийн эрсдэлээ тооцоод үзэхээр зэрэг 2,7 сая иргэн өнөөдөр зүрх судасны өвчлөлийн эрсдэлтэй. Тэр хэрээрээ манай зүрх судасны үндэсний төвийг зорих иргэдийн тоо нь бас их юм байна даа л гэж ингэж харагдаж байгаа юм. Тэгээд манай 3 дугаар эмнэлэг энэ танилцуулсан материал дээр бол оношилгооны 67 хувийг хийдэг. Хагалгааны үндсэндээ 95 хувийг дангаараа хийдэг гэж танилцуулж байна л даа. Тэгэхээр би эндээс юу гэж дүгнэж байгаа гэхээр зэрэг хэр зэргийн ачаалал 3 дугаар эмнэлэг дээр явдаг юм бэ л гэдгийг би зүгээр бодож үзэх гэж байгаа юм. Одоо бодит амьдрал дээр хүмүүс 3 дугаар эмнэлэгт үзүүлж, шинжилгээ, эмчийн зөвлөгөө авах гэж ямархуу хэмжээний очертой байдаг билээ. Цаг олддог, олддоггүй гэдэг ийм асуудлууд байнга л явдаг. Тэгэхээр энэ асуудлыг ингээд төвлөрүүлсэн ийм хэлбэрээр цаашид яваад байх нь ер нь зөв үү. Оношилгоог орон нутаг руу чиглүүлсэн ийм оношлохгүй юм уу гэдэг ийм 1 дүгээр асуулт нь оношилгоонуудаа ер нь орон нутгийн хэмжээнд хийдэг болчихъё л доо. Үнэхээр эмчилж чадахгүй хүнд онош нь гарч ирсэн баталгаажсан бол 3 дугаар эмнэлэгтээ ирдэг ийм хэлбэр байвал яасан юм бэ.

2 дугаарт нь энэ зүрх судасны өвчнөөс нь урьдчилан сэргийлэх чиглэлээр манайхан юу ярьж байна. Ямар бодлого явуулж байна. Одоо 2030 он гэхэд зүрх судасны өвчлөлийн тоо чинь дахиад 2,6 гэдэг чинь 100-аар үржүүлэхээр 260 хувиар нэмэгдэхээр байна гээд ийм айдас дагуулсан том тоонууд оруулаад ирчихсэн л байна л даа. Тэгээд Эрүүл мэндийн яам бодлогын хувьд энэ дээр ямар бодлого барьж байгаа юм бэ. Эдийн засгийн байнгын хороо бид бол эдийн засгийг либералчлахтай холбоотой бодлогыг байнга явуулах ёстой ийм Байнгын хороо гэж ингэж үзэж байгаа. Хувийн, гаднын өндөр зэрэглэлийн эмнэлгүүд Монголд орж ирэх хүсэл зөндөө л байдаг юм байна лээ шүү дээ. Газрын асуудал маш хүндрэлтэй байдаг. Тэдгээр эмнэлгүүдийг оруулж ирвэл гадагшаа урсаж байгаа энэ долларын чинь урсгал дотроо үлдэх бас ийм магадлалтай болно шүү дээ. Зайлшгүй чанартай эмнэлгийн чиглэлтэй мөнгөнүүд нь гадагшаа тэгээд гадаад эмч нарт төлбөр болдог юм байгаа биз. Хүнд өвчтөнөө харах сахиулаас өгсүүлээд, түүнтэй холбогдох зардлууд бүгд л Монголдоо хоцорно шүү дээ. Энэ дээр ер нь ямар бодлого байгаа юм бэ гэж.

Дараа нь бас эмч нар ороод ирчихсэн байгаа учраас энэ ковидтой холбоотойгоор нас баралт, гэнэтийн нас баралт ихэслээ л гээд яриад байгаа юм. Энэ дээр ер нь ямар тоо мэдээ байна. Вакцинтай холбоотой янз бүрийн юм байгаа юу.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Заяабал гишүүний асуулт дотор бараг хариулт нь байж байна даа. Тэгэхээр Монгол улсад зүрх судасны өвчлөлтэй холбоотой нас баралт бол тэргүүлэх шалтгаан. Энэ өвчин яаралтай тусламж, түргэн тусламж шаарддаг. Цаг хугацаа алдах тусам эндэх эрсдэл улам нэмэгдэж байдаг. Зөв оношлоод цаг хугацаанд нь зөв эмчилгээ хийж, түргэн тусламжийг түргэн хүргэж чадах юм бол нас барах битгий хэл бүүр тахир дутуу ч болохгүй хөдөлмөрлөх чадвараа хүртэл алдахгүй байх ийм боломжтой ийм өвчин. 2024 онд 4559 хүн эндэж, нас барсан. Тэгэхээр тусламжийг орон нутагт нь хүргэх нь өөрөө хамгийн чухал. Тантай санал нэг байгаа. Бид орон нутгаас Улаанбаатар луу ирдэг энэ урсгалыг зогсоох зорилгоор түрүүн хэлсэн түргэн тусламж, яаралтай тусламжийг түргэн очоод түргэн авсан хүндээ яаралтай төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлээд, эрчимт эмчилгээг нь орон нутагт нь үзүүлдэг байх дараагийн төслийг бид одоо танилцуулах гэж байгаа. Үүний дараа танилцуулна. Тэгэхлээр энэ бол хоорондоо уялдаа, шүтэлцээтэй. Харин Улаанбаатар хотод баригдах энэ нарийн мэргэжлийн төв нь ахисан шатын оношилгоо, эмчилгээг үзүүлэх, нөгөө талаасаа Монгол Улсаас гадаад руу урсаж байгаа жилд 250 тэрбум төгрөгийг зогсооход тодорхой хэмжээний хувь нэмэр оруулна.

Өнөөдөр бид нар хүний амь нас, хөдөлмөрийн чадвар алдалт, дээрээс нь гадагшаа урсаж байгаа урсгалыг нийлүүлээд бүгдийг нь мөнгөн дүнгээр үнэлэх юм бол бид энэ төслийг хэрэгжүүлснээр олон олон иргэдээ гадаад явуулахгүй байх энэ боломж бүрдэж байгаа юм.

Нөгөө талаасаа гадагшаа урсаж байгаа урсгал бол нөгөө ахисан шатдаа илүү гардаг. Мэдээж цочмог байдлаар судсанд бөглөрсөн, харвасан иргэд бол гадаад руу тийм хурдан явж чадахгүй. Тийм учраас бол энийг бид орон нутагт нь илүү хийх энэ бодлогын ажил явж байгаа шүү. Энэ бол одоо яг үүний дараагийн төсөл танилцуулагдахад хэлэлцэгдэнэ. Тэгээд би энэ дээр бас илүү дэлгэрэнгүй тэр үед ярья. Тэгэхээр та бас л яг л өвчний нөхцөл байдлыг онцгой анхаарч байна. Тэгээд

нас баралт энэ тэрийг харвал ерөөсөө л яг хөдөлмөрийн насны иргэд энэ нөхцөл байдалтай байгаа. Урьдчилан сэргийлж бид чадах уу гэж ярьж байгаа юм. Урьдчилан сэргийлэх чадах ёстой. Ялангуяа Монгол Улсад хүн амын өвчлөлийг судалдаг Степ судалгаа гэж байдаг. Энэ степ судалгаа дотор бол монголчуудын дунд цусан дахь муу өөхний агууламж бол хэт өндөр байгаа нь судас дотор бөглөрөх, судасны ялангуяа зүрхний титэм судасны бөглөрлийн бас нэг гол шалтгаан болж байгаа. Бас бид энэ төвлөрлийг бууруулах зорилгоор зөвхөн 3 дугаар эмнэлэг биш олон, олон Улаанбаатар хотын эмнэлгүүд, тэр битгий хэл бас орон нутагт хүртэл хийдэг сайн туршлагатай болсон. Тухайлах юм бол Эрдэнэтэд бол сайн ангиографийн аппараттай болчихсон. Катлаб ажилладаг болчихсон. Иргэдээ Улаанбаатар хот руу зөөх шаардлагагүй хэмжээнд бас болж чадаж байгаа зүйлүүд байж байна. Муу жишээ гэх юм бол өнгөрсөн жил Баянхонгор аймгаас харвалттай хүнийг Улаанбаатар луу зөөж явж байгаад машин осолдоод, эмч, сувилагч нар нь хамт осолдсон, эндсэн муу тохиолдол байж байна. Тийм учраас бид энэ асуудлыг бол бүр цогцоор нь шийдэж, эрт илрүүлэгтэй нь давхар шийдэж, эрсдэлтэй бүлгүүдийг тогтмол гаргаж ирж байх ёстой.

Өнөөдөр артерийн даралтаа хэмжүүлээд хяналтад хөнгөлөлттэй эмээ аваад ууж байгаа иргэдийн тоо ердөө 50 хувьтай байгаа байхгүй юу. Энийг бид эрт илрүүлгийнхээ тусламжтай, хөнгөлөлттэй эмээрээ дамжуулаад 60 хувьд хүргэчихье гэсэн 2026 оны том бас зорилго тавьчихсан байгаа. Тэгэхээр бид аажмаар Монгол Улсад ч гэсэн ялгаагүй өндөр хөгжилтэй орон шиг зүрхний шигдээсээр иргэдээ алддаггүй байх энэ тогтолцооны том алхам өнөөдөр бид ярьж байна гэж харж байна.

Р.Сэддорж: Заяабал гишүүн тодруулж асууна.

Б.Заяабал: Тэгэхээр Чинбүрэн гишүүн ээ, миний асуусан гол асуулт бол эрүүл мэндийн салбарт энэ либералчлал буюу хувийн эмнэлгүүдийг яаж дэмжиж оруулж ирэх вэ гэдэгтэй холбоотой бодлогын асуудал асуусан. Тэн дээр бас хариулт өгөөч ээ. Солонгос болон гаднын бусад оронд бол ерөнхийдөө хувийн эмнэлгүүд байдаг. Эмнэлгүүд нь өөрсдөө тоног төхөөрөмжөө, өөрсдийнхөө ашгаараа тоног төхөөрөмжийг шинэчилдэг. 2, 3 жил ашиглаад, 2, 3 жилийн өмнө ашигласан тоног төхөөрөмж нь хуучраад, дараагийн орнууд руу явуулдаг ийм хэлбэр байдаг шүү дээ. Тэгэхээр энэ эрүүл мэндийн салбар яг ийм ашигтай, өөр өөрийнхөө асуудлыг өөрөө шийддэг ийм боломжтой болох, хэзээгээр ийм боломжтой болох боломжтой вэ гэдэг талаар 1 дүгээрт.

2 дугаарт энэ монголчуудын өвчлөл өндөр байна. 2,7 сая иргэн нийт иргэдийн 75 хувь нь зүрх судасны өвчлөл өндөртэй гээд хэлчихсэн. Үүнээсээ урьдчилан сэргийлэхийн тулд бид нарын амьдрал ахуйтай холбоотой асуудлууд байна уу. Хоол ундтай холбоотой асуудлууд байна уу. Энийг урьдчилан сэргийлэх ямар арга, урьдчилан сэргийлэх үүднээс ямар бодлогын арга хэмжээ Эрүүл мэндийн яам авч явж байгаа вэ.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: 2020 онд Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны том реформ хийсэн. Энэ реформын гол зорилго бол үр дүнтэй гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт аваад, тэр нь төр болон хувийн хэвшлийн эмнэлгээс үл хамааран санхүүжилт аваад цалин хөлс, тоног төхөөрөмж мөн урсгал зардлаа даадаг байхаар уг нь төлөвлөж хийсэн боловч ковид цар тахлын дараагаар олон нийтийг хамарсан

өвчлөлтэй холбоотой санхүүжилтийн гажуудал үүсээд, энэ нь цаашаа үргэлжлэх боломжгүй болоод, тэгээд улсын эмнэлэг болон хувийн эмнэлгүүд санхүүжилт нь тоног төхөөрөмжийн шинэчлэл, цалин хөлс нэмэгдүүлэх хэмжээнд хүрч чадахгүй байгаад байгаа нэг зовлон байгаа юм. Тийм учраас 2026 онд оруулсан 1 том хөтөлбөр бол бид Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, сайжруулах 9 зорилготой 30 ажил давхар өргөн барьсан байгаа. Ингээд 2028 оноос яг ингэж хэрэгжих ийм том зорилго тавьчихсан ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Заяабал гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байна.

Б.Заяабал: Тэгэхээр эрүүл мэндийн салбарыг бүхэлд нь либералчлах ийм том бодлого бол зайлшгүй явуулах ёстой шүү Чинбүрэн сайд аа. Энэ дээр тодорхой бодлого авч явуулаарай. Тэгэхгүй бол энэ чинь төсвөөс мөнгө гаргаад, зээлийн мөнгө ч гэсэн ингээд л төсвөөс гарч байгаа мөнгө. Энэ удаагийн эмнэлгийг дэмжих үү. Дэмжихээс өөр арга байхгүй. Тэгэхдээ энэ эмнэлгийг баригдчихна. 120 хүний эмчлэх ийм чадвартай, хүчин чадалтай, орчин үеийн эмнэлэг болно гээд л байна. Дахиад л халаалт, дулаан, энд ажиллаж байгаа эмч нарын цалин хөлс гээд дахиад л төсөв дээр бөөн дарамтууд орж ирнэ. Тийм учраас энэ эрүүл мэндийн салбарыг либералчлах ийм бодлогыг зайлшгүй авч явуулах ёстой шүү гэдэг ийм саналыг дахиж хэлье.

Тэгээд эмч нар ороод ирчихсэн байгаа учраас бас дахиад нэг юм асуучихъя. Энэ ковидтой холбоотойгоор цус өтгөрөл ч гэдэг юм уу, гэнэтийн нас баралт аягүй ихэсчхээд байна. Үүний холбоотой ийм нөлөөллийг тогтоосон судалгаа байгаа болов уу. Өчигдөрхөн яриад, өнөөдөр уулзъя гэсэн хүмүүс гэнэт л нас барчихсан. Тэгээд л Зүрх судасны өвчний өвчнөөр гээд. Сүүлийн үед нийгэмд маш их ийм мэдээ яваад байна. Энэ дээр нэг хариу хэлээд өгөөч.

Р.Сэддорж: 4 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Ц.Төмөр-Очир: 3 дугаар эмнэлэг Төмөр-Очир. Ковидын жилүүдийн нас баралт, ялангуяа зүрх, тархины судасны эмгэгийн шалтгаант нас баралт буюу тархины харвалт, зүрхний шигдээсний нас баралтыг ковидын өмнөх жилүүдтэй харьцуулахад бол огцом нэмэгдсэн өгөгдөл зүй бол гараагүй байгаа. Гэхдээ дэлхийн түвшинд бол зарим нэг судалгаануудаас ковидын үед цус өтгөрөх хам шинж илүү явж байна, давамгайлж байна. Түүнтэй холбоотой өөрчлөлт, хүндрэлүүд өгч байна гэсэн судалгаа мэдээллүүд байгаа. Манай яг нас баралтын юугаар эмнэлгийн хэмжээнд зүрх мэдрэлийн тусламж голлож лавлагаа тусламж үзүүлж байгаа эмнэлгийн хувьд бол ковидын жилүүдэд бол урдах онуудтай харьцуулахад бол нас баралт огцом өсөөгүй байгаад байгаа.

Р.Сэддорж: Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Өдрийн мэнд хүргэе. Зүрх судасны үндэсний төв байгуулагдаж байгааг бол зарчмын хувьд үнэхээр дэмжиж байна. Гэхдээ бид энд суугаад Эдийн засгийн байнгын хорооны гишүүд бас зөндөө л ярьж байна л даа. Эдийн засгийн тооцоолол, тэгээд үр өгөөж, ер нь энэ зээл туслан хэмжээний эргэн төлөлт, хүүгийн төлбөр гээд энийг ярихаас өөр арга байхгүй. Хэтэрхий жоохон бүдэг, тийм тойм төдий ийм мэдээллээр гишүүдийг хангаж байгаад бол бас харамсаж байна. Энэ их том төслийн хувьд хэрэгжүүлэх хугацаа бас урт байна. Энийг бол зүрхний өвчин, зүрхний өвчтэй хүмүүс бол хүлээхгүй л дээ. Тийм ээ. Тэгэхээр Монгол Улсын хэмжээнд зүрхний өвчлөл, нас баралт, эндэгдэл маш их өндөр байгаа нь бол хүн

болгон мэдэж байгаа. Ийм үндэсний төв тусгайлсан эмнэлэг хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ миний нэг гайхаад байгаа зүйл нь заавал о энэ Шастины нэрэмжит 3 дугаар эмнэлгийн хажууд аваачаад бөөрөнд нь наалдуулаад холбоод барьчихдаг нь ямар учиртай байдаг юм. Тэр томоохон хэмжээний ийм их зээл тусламжийн ийм үнийн дүнтэй зээл тусламжаар баригдах энэ төслийг бол ямар газар мундсан биш. Сайхан сэлүүхэн агаар сайтай газар аваачаад барьчихсан бол илүү бас үр дүн, өгөөж нь байх байсан байх л гэж бодож байна. Тэнд чинь бараг онгоц битгий хэл машин, хүн ч явж орох зайгүй л тийм газар болчихсон шүү дээ. 3 дугаар эмнэлгээ харахаа больчихсон шүү дээ бид нар чинь. Тэгэхээр тэнд шахцалдуулаад барьчихсан энэ том төслийг хэрэгжүүлээд эхэлж байгаад бол харамсаж байна. Барилга объектын хувьд.

Өнөөдрийн түвшинд бүгдээрээ барилга объект л яриад байгаа. Сургууль, цэцэрлэг ярихаар л барилга объект ярьдаг. Тоног төхөөрөмж ярьдаг. Эмнэлэг ярихаар л бас тэгдэг. Тэгэхээр хүний асуудал, тэнд ажиллах мэргэжилтэн, боловсон хүчин, зүрхний нарийн мэргэжлийн эмч нар, сувилагч нар, асрагч нар гээд хүний нөөцийн асуудал нь ямар байгаа юм. Энд бэлтгэгдчихсэн эмч нар ажиллаж байна л гэж байна. Тэгэхээр бид хүний төлөө л ярих ёстой юм л даа. Тэрнээс тэр барилга босох, тэгээд хэдэн давхар байх, тэнд хэчнээн сая еврогийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэх энэ тэр нь бол дараагийн асуудал.

Тэгээд энэ төсөл 2026 онд эхлээд 2032 онд дуусна гэж байгаа юм. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийг аваачаад, бид нар төслийн явцтай 1, 2 жилийн дараа бас танилцаж болох байх л гэж бодож байна.

Р.Сэддорж: Одоо гишүүд бол ингэж үзээд байгаа л даа. Заавал зээл авах шаардлага байна уу л гэж бас эхнээсээ л ярьсан. 34,9 сая доллар нь зээл, 22,5 сая доллар нь бол буцалтгүй тусламж. Бид бол саяхан 7 их наядтай байсан төсөвтэй улс одоо 30 гаруй их наядын төсөвтэй болчихсон. Тэгээд энэ дээр бодох ёстой юмнууд их байна. Тэгээд зээл л авах дуртай. Шахаад байдаг юм шиг байгаа юм. Тэгээд энэ дээр энд байгаа хариуцлагатай хүмүүс гишүүдийн үгийг бас тодорхой бодох хэрэгтэй. Тэгээд Очирбат дарга 1 минут энэ гишүүдийн асуултад бас ерөнхийд нь хариулаач ээ.

Д.Очирбат: Бүх асуултууддаа Эрүүл мэндийн сайд Чинбүрэн сайд хариулчихсан. Тэгээд мэдээж зүрх судасны өвчлөлөөрөө Монгол Улс дэлхийд тэргүүлж байгаа. Тэргүүлэх чиглэлийн Монгол улс дотроо өвчлөлийн тэргүүлэх чиглэлийн зүрх судасны өвчлөл байгаа. Тусламж авч чадахгүй жилдээ 18 мянган хүн эрүүл мэндийн тусламж авч чадахгүй, яаралтай тусламжаа авч чадахгүй байгаа хүмүүсийн тэр өвчлөлийнх нь тоо бол бас энэ зүрх судасны өвчлөлөөс бас хамаарч байгаа. Тэгэхээр энэ том төсөл нэгдсэн 3 дугаар эмнэлгийнхээ, 3 дугаар эмнэлэг маань өөрөө зүрх, мэдрэлийн мэс заслын чиглэлийн нэгдсэн эмнэлэг. Энийгээ түшиглэж бид энэ гаднын зээл тусламжийг авч, улам өргөжүүлэх, өсөн нэмэгдэж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээ улам чадавхжуулах, дэлхийн түвшинд хүргэх, гадагшаа гарч үйлчлэх, гадагшаа гарч явж байгаа монголдоо эмчлэгдэж чадахгүй байгаа 26 нэр төрлийн өвчнөөсөө..../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут.

Д.Очирбат: Гадагшаа Монголдоо эмчлэгдэж чадахгүй байгаа энэ 26 нэр төрлийн өвчлөлөөсөө бид адаглаад энэ төвийн үйлчилгээ нээгдэхэд энэ эмнэлгийн тусламж үйлчилгээг зүрх судасны чиглэлээрээ авч чаддаг болох ийм том зорилтыг

л тавьж ажиллаж байгаа. Тийм учраас энэ төсөл зээл, энэ хамтын ажиллагаа, Люксембургийн Засгийн газар, Европын сэргээн босголтын хамт олонтой олон жилийн хамтын ажиллагааны үр дүнд бас бид санал тавьж, хийж хэрэгжүүлэхээр хүсэлтийг тавьж, энэ маань хэрэгжиж бас Монголын иргэддээ тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх ийм сайхан том эмнэлэгтэй болох тусламж, үйлчилгээ нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй, баяртай байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал. Хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээр”-ийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна. Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

18.23 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хөтөлбөрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Чинбүрэн танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Ж.Чинбүрэн: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан “хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх, тэгш боломж бүрдүүлэх, эрүүл мэндийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, гамшгаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлэх, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох” зориулалтын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс дараах 4 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

1.Засгийн газраас 2026 оны боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбоотойгоор боловсролын салбарт тулгамдаж буй сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын анги дүүргэлтийг бууруулж, хүүхэд багачуудын суралцах орчныг сайжруулах зорилгоор 130 сая ам.доллар-ын хөнгөлөлттэй зээлээр 31 сургууль, 9 цэцэрлэг барьж байгуулах, эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн 2 дахь үе шат.

2.Техникийн болон мэргэжлийн боловсролын чанарыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, ажиллах хүчний хомсдол үүсээд байгаа салбаруудад

чиглэсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор 20 сая ам.доллар-ын хөнгөлөлттэй зээлээр мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтолцоог орчин үеийн технологид суурилсан бэхжүүлэх Монгол Улсын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх төсөл.

3.Улсын хэмжээнд яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг өргөжүүлэн шинэчлэх, хот, хөдөөгийн ялгааг арилгаж, түргэн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 225 сая ам.доллар-ын хөнгөлөлттэй зээлээр аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл.

4.Гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх, онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 100 сая ам.доллар-ын хөнгөлөлттэй зээлээр Монгол улс дахь гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төслийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөөд байна.

Азийн хөгжлийн банктай байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн зээлийн ерөнхий нөхцөлийн хувьд хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээл нь тогтмол 2 хувийн хүүтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Энгийн эх үүсвэрийн зээл нь 5,15 хувийн хөвөгч хүүтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд 0,15 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлтэй болно.

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг байгуулснаар Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад олгох зээлийн эх үүсвэрийг баталгаажуулж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх юм.

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, гэрээний төсөл, танилцуулга, материалуудыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Та бүхэн гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөлтэй танилцан, хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гантөмөр Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Должинсүрэн Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Нарангэрэл Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга, Баянмөнх Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хүрэлбаатар Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Марал Сангийн яамны санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн.

Хөтөлбөрийн төслийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Заяабал гишүүнээр тасалъя. Ирцийн дарааллаар эрэмбэлэгдээд, Улсын Их Хурлын гишүүн Батболд.

Р.Батболд: 1 юм асууя. Энэ 105 сая доллароор 31 сургууль, 9 цэцэрлэг гэххэв үү. Нийтдээ 40 объект уу. 41 сургууль юм уу. Тэгээд энэ хүрэх юм уу гэж асуух гээд байна 1 дүгээрт. Хэчнээн хүүхдийн багтаамжтай гэдэг юм уу, хэчнээн хүүхдийн ортой цэцэрлэг барих юм. Хэчнээн хүүхдийн суудалтай сургууль барих гэж байгаа юм бэ. Энэ чинь одоо шууд 40-д нь ингээд бүгд адилхан гэж бодоод хуваачих юм бол 2,5 сая доллар ч юм уу. Энэ чинь 8, 9 тэрбумд амжих юм уу.

Дахиад 2 жилийн дараа баахан магадалгаа хийгээд, нөгөө зээлийн сургуулиуд чинь баригдаж дуусдаггүй гээд явчих юм биш биз дээ. Энийг хариулж өгөөч.

Р.Сэддорж: 6 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Х.Батжаргал: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал байна. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ 32 сургууль, 9 цэцэрлэгийн барилгын ажил хүчин чадлаасаа хамаараад харилцан адилгүй, төсөвт өртгийн хэмжээ бол янз бүр байгаа. Тухайлах юм бол 960 хүүхэдтэй сургуулийн барилга 16,2 тэрбум байхаар, 320 хүүхэдтэй гэхэд 7,7 тэрбум гээд энэ яг өнгөрсөн онуудад яг баригдсан төсөвт өртгийн хэмжээгээрээ тооцож гаргасан байгаа юм. Бас бид эргээд бас энэ дээр стандарт, төсөвт өртгийн хэмжээ, зураг төслийг ч гэсэн бас эргэж харахаар асуудлууд бас байгаа. Яагаад гэвэл ядаж 1 ч гэсэн сургууль, 1 ч гэсэн цэцэрлэгийг илүү оруулахын тулд энэ одоогийн явагдаж байгаа хүчин чадал, шаардлагатай төсөвт өртгөөр нь оруулсан байгаа юм. Хэрвээ хамгийн сүүлийн 1 хэвийн зургийн жишгийн төсөвт өртгөөр явах юм бол бараг талаар нь 20 сургууль, цэцэрлэгийн төсөвт өртгийн хэмжээ шаардахаар байгаа боловч бид хэд стандартыг бол хуучин мөрдөж байгаа стандартаар тооцож төсөвт өртгийг оруулсан байгаа.

Р.Сэддорж: Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Би яг хүрэх үү л гээд байгаа юм. Өнгөрсөн жилийнхээр хийчихсэн. Одоо наадах чинь ирэх жил тендер нь зарлана. Тэгээд тэрний дараа ажилд наадах чинь бараг барилгын ажил нь эхлээгүй байхад магадлан хийх болчихож байгаа юм биш үү. Энэ чинь нөгөө 2 жилийн дараа билүү юу билээ. Магадлан хийдэг чинь 2, 3 жилийн дараа билүү. Тэгээд баахан зээл авчихсан. Ажил нь ч эхлээгүй, магадлан хийлгэх баахан сургуультай болчих юм биш биз дээ. Би зүгээр тийм юм дээр санаа зовоод байна л даа. Их олон тооны араас хөөцөлдөөд, наадах чинь хүрэхгүй баахан төсөв тавьчих вий дээ л гэж бодоод байна.

Р.Сэддорж: Сангийн яам. 1 номер.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Азийн хөгжлийн банк дээр байгаа 32 сургууль, 9 цэцэрлэгийн хувьд бол бид нар их өгөгдлийн хүрээнд яг 108 сургууль. Азийн хөгжлийн банкны төслүүдийн хувьд бол яг худалдан авах ажиллагааны журам бол Азийн хөгжлийн худалдан авах ажиллагааны журмаар явдаг. Хамгийн дээд талдаа 960-тай сургууль, хамгийн багадаа 320-той сургууль, цэцэрлэгүүдийн хувьд 100-150 ортой. Одоо яг улсын төсвөөр баригдчихдаг дундаж өртгөөр байгаа учраас хэрэгжих боломж, нөгөө талдаа нийслэлд хэрэгжих төслүүдийн хувьд бол нийслэл өөрөө газар

чөлөөлөлттэй холбоотой зардлуудыг гаргаж байгаа. Азийн хөгжлийн банк дээр явж байгаа төслүүдийн хувьд бол Монгол тал дээр зарим оролцоо нь бол дэд бүтэц дээр орж ирдэг. Хэрвээ яг энэ төлөвлөсөн өртөг дээрээ бид нар амжихааргүй ийм тооцоолол гарвал Монголын талын үүрэг оролцоо дээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг нь хийгээд .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Монголын талын оролцоон дээрээ дэд бүтэцтэй шаардлагатай зарим хөрөнгө оруулалтуудыг хийгээд явна гэж ийм тооцоолол байгаа. Азийн хөгжлийн банкны боловсролын салбарын энэ төсөл одоо сургууль, цэцэрлэгийн бүтээн байгуулалтууд хийж байгаа. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах гээд төсөл Азийн хөгжлийн банканд хэрэгжиж байгаа. Үүний нэмэлт санхүүжилт болгоод явж байгаа. Нөгөө талдаа төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой төслийн нэгжийн зардал ч юм уу урсгал зардалтай холбоотой зардал гарахгүйгээр одоо байгаа бүтэц дээр нь зохион байгуулалт хийгээд энэ төслийг хэрэгжүүлэх гэдгээр зохион байгуулалт хийсэн.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд. Тэр Батчимэг гишүүн хэлсэн шүү дээ тээ. Заавал тийм жихэлдсэн газар тийм чухал эмнэлгийг барьдаг. Тэгээд ер нь дахин төлөвлөлт эд нарт оруулж болдоггүй юм уу. Энэ нөгөө гэр хорооллын бас сайхан талбайтай газрууд байгаа шүү дээ. Тэрийг бас та бас сайн тэмдэглэж аваарай. Тэгээд зүрх судасны өвчин гэдэг чинь бол тийм уужуу тайвуу, саруулхан газар байх ёстой биз дээ. Тэгэхээр энэ тал дээр бас бодоорой гэдгийг хэлье. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Бараг нэг их наяд гаруй төгрөгийн зээлийг авах гэж байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ зээл болгоны ард үр дүнд суурилсан хөрөнгө оруулалт явах ёстой. Манай Эдийн засгийн байнгын хороо бол түрүүн Заяабал гишүүний хэлдгээр эдийн засгийн хувьд нь ямар үр ашигтай байх вэ гэдэг дээр л гол дүгнэлт гарах байх гэж бодож байна. Тэгэхээр би Байнгын хорооны даргаас асуухад энэ чиглэлээр гишүүдийн өгсөн ийм тусдаа тусдаа санал, дүгнэлт дээр тусгагддаг юм уу. Эсвэл манай Байнгын хороо нэгдсэн ийм тогтоол хэлбэрээр дүгнэлтээ гаргаж болохгүй юу. Өөрөөр хэлбэл заавал биелүүлэх шинжийг агуулсан ийм тогтоолоор манайх санал, дүгнэлтээ гаргахгүй бол тэгээд энд нэг хэдэн гишүүн саналаа хэлдэг, тэгээд тэр нь хэрэгжиж байгаа ч юм уу, үгүй ч юм уу ийм байдалтай болчих гээд байгаа байхгүй юу. Би энэ хариултуудаас нь хараад байхад түрүүний танилцуулга танилцуулсан байдлаар хараад байхад. Тэгээд ийм байж болдог юм болов уу. Энэ дээр та хариулж өгөөч ээ.

2 дугаарт нь би бас л түрүүний саналаа л хэлэх гээд байгаа юм. Асуулт дээр гарсан саналаа. Энэ байшин барьснаараа асуудлууд шийдэгдэхгүй. Урьдчилан сэргийлэх ажил, хүний нөөцийн тогтолцоо зэрэг цогцоор нь энэ асуудлыг авч үзэхгүй бол байшин бариад асуудал шийдэгддэг бол зөндөө л асуудал шийдэгдэхээр цаг хугацаа бидэнд өнгөрлөө. Тэгэхээр энийгээ яаж оношилсон байдаг юм бэ. Зөв онош ер нь тавьсан юм уу. Одоо түргэн тусламжийн 110 автомашин авна гэж байна. Одоо тоёотагийн л машин авах гэж байгаа байх. Зөв. Тэгээд би хэлээд байгаа юм. Энд нисдэг тэрэг нэг ч байхгүй. Магадгүй төрийн байгууллагад нисдэг тэрэг байх нь оновчтой биш байж магадгүй. Яагаад гэвэл дарга нар нь унаад байж магадгүй. Тийм учраас энийг хувийн хэвшилд, даатгал байдаг юм уу ямар хэлбэрээр байдаг юм шийдэх хувилбар ер нь байна уу. Жишээлбэл энэ хэрэгжүүлж байгаа төсөл дээр тийм хувилбар байгаа юу. Тэгэхгүй болохоор түрүүний юуг ол дэмжсэн. Харин энэ дээр жоохон эргэлзээд л байна. Энэ төслүүд дээр.

Тэгээд өмнө нь зөндөө олон төсөл Монгол Улсад хэрэгжсэн л дээ. Тэгээд тэр төслийг яг нэн шаардлагатай газар нь хэрэгжүүлдэг үү, эсвэл нэг эрх мэдэлтэй хүмүүс нь дараагийн сонгуулиа бодоод тойрогтоо хэрэгжүүлчихдэг үү. Тэгээд надад бол нэг тийм жоохон үл итгэх байр суурь бол байна. Яагаад гэвэл энэ задаргааг нь сайн мэдэхгүй байна. Яг хаана, хаана хэрэгжүүлэх гээд байгаа юм. Үзэмжээрээ хандах асуудал энэ дээр гарах юм биш биз дээ. Мөн л гаднын банкнаас зээл аваад Ховд аймгийн бүх сумыг хатуу хучилттай замаар холбосон байна лээ шүү дээ. Тэгсэн мөртөө боомтууд нь холбогдоогүй. Бусад эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Тэгээд энийг нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор нь яг яаж эрэмбэлсэн юм бэ. Тийм учраас энэ дээр заавал биелэгдэх шинж чанартай дүгнэлт гаргамаар байна.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр ерөөсөө яг Монгол Улс шиг ийм уудам өргөн нутагт хүн ам сийрэг суурьшсан орон нутагт бид түргэн тусламжийг шуурхай хүргэдэг байх тогтолцооны төсөл энд орсон байгаа юм. Тэгэхээр таны бас сая асуудаг асуулт зөв. Ер нь яаж аймгуудаас сонгосон юм гэж. Тэгэхээр энэ дээр төслийн танилцуулга дээр та харж байгаа байх. 17 аймаг гэж орсон байгаа юм. Тэр ороогүй аймгууд нь юу вэ гэхлээр жишээлбэл Ховд, Увсад дөнгөж саяхан Азийн хөгжлийн банкаар эмнэлгийн өргөтгөл баригдаад, цоо шинэ хагалгааны хэсэг, яаралтай тусламж, түргэн, эрчимт эмчилгээний тасгууд нь хийгдчихсэн байж байгаа. Тийм учраас давхцаж хийхгүй. Тэгэхлээр та энэ нэрсүүдийг нь бас хараарай. Мөн төсөл хэрэгжүүлэхээс өмнө зөвлөх багууд бүх аймгуудаар явж, яг энэ түргэн тусламж, харвалт шигдээс, гэмтэл осол, яаралтай тусламжийг хийхэд аль аймагт юу дутуу байгаа юм бэ гэдгийг бүгдийг нь нэг бүрчлэн явж шалгаж байгаа. Одоо бараг Азийн хөгжлийн банкны зөвлөх багийнхан нь өнөөдөр бараг дуусах гэж байна. Бүх аймгуудаар яваад дуусах гэж байна. Тэгэхээр энэ бол цогц арга хэмжээ шүү. Зөвхөн байшин барих зүйл биш. Та бүхэн энэ хөрөнгийн зарцуулалтыг хараарай. Зарим шаардлагатай аймгуудад байшин барилга, эмнэлгийн тоног төхөөрөмж, тэгээд яаралтай түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлэг. Энэ бол зүгээр нэг тоёотагийн түргэн тусламжийн машин биш. Энэ илүү явдаг эмнэлэг гэж ойлгоорой. Жишээлэх юм бол интернэт сайттай ч юм уу, интернэттэй явуулын автомашин, сумаас иргэдийг аймаг руу зөөхдөө тусламжийг камераар дамжуулан үзүүлж байна. Азийн хөгжлийн банкны өмнөх төсөл нь одоо хэрэгжиж байгаа төсөл нь нэгдсэн удирдлагын тогтолцоо, нэгдсэн дуудлагын тогтолцоо Монгол Улсад одоо хийж байгаа. Энэ төсөл хэрэгжээд эхэлсэн. Нэг ёсондоо түргэн тусламжийн нэгдсэн дуудлагын тогтолцоо Монгол Улсад бий болж байгаа. Үүгээрээ дамжуулаад аль ч аймгаас ярьсан дуудлагын төв хүлээж авч, мэргэжлийн зөвлөгөө машин дотор нь хүн тээвэрлэж байхад нь үзүүлэх юм. Ингээд аймгийн нэгдсэн эмнэлэг дээр ирэхэд хаана, ямар тасаг, ямар хүн хүлээж авах гэж байгаа гэдгээ мэддэг болчихсон. Шууд хүлээж аваад тэгээд түргэн тусламжийг шуурхай үзүүлнэ. Эрчимт эмчилгээ, төрөлжсөн мэргэжлийг үзүүлэх тэр хэрэгтэй тоног төхөөрөмж бүрийг суулгана.

Нэг ёсондоо аймгаас Улаанбаатар луу явуулахгүй гээд байгаа зорилго маань энд байгаа. Ер нь яаралтай тусламж бол 2 цаг дотор л тусламж үзүүлэхгүй бол бид хүнээ алдаад байгаа шүү дээ. Тийм ч учраас 2024 оны статистик тоог та бүхэнд танилцуулъя. 18,200 гаруй иргэн эндсэн байдаг 2024 онд. 70 хувь нь эмнэлэгт нас бараагүй. Эмнэлгийн гадуур нас барсан. Яг мэргэжлийн судлаачдын хийсэн анализ хийгээд үзэхээр 6 мянгыг нь аварч болох боломжтой байсан гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ болгоныг л бууруулах ийм том хөтөлбөр. Тэгэхээр бид бүсчилсэн оношилгоо эмчилгээний төв гээд л түүнд нь очдоггүй, иргэд нь очихгүй, тэгээд тэр

нь хөгжсөн ч юм байхгүй биш, харин түргэн тусламж, яаралтай тусламж түргэн очиж чадаад, түргэн очсоноороо мэргэжлийн туслалцаагаа үзүүлж чаддаг аймаг бүр дээр энэ тогтолцоог хийх ийм төсөл юм. Тэгээд энэ дотор орж байгаа задаргаанууд энэ тэр бол дандаа цогц арга хэмжээ байгаа. Цогц арга хэмжээ. Хүний нөөцөөс авхуулаад шаардлагатай тоног төхөөрөмж, барилга байшин, дэд бүтцийг нь бүгдийг нь хийгээд, тэгээд 2 жилийн дараа гэхэд Монгол Улсад түргэн тусламж түргэн хүрдэг болчихсон, нутаг бүр дээр ижил эмнэлгийн тусламж, яаралтай тусламж очдог болно гэсэн ийм том төсөл байгаа юм.

Р.Сэддорж: Нэмж хариулт байгаа юу. Боловсролын яам 6 номер.

Х.Батжаргал: Тэгэхээр Боловсролын яамны тухай сая бас Сангийн яамнаас хэллээ. Яг их өгөгдөлд суурилсан аливаа хүний оролцооноос зайлсхийсэн ийм төлөвлөлтийн системийг нэвтрүүлээд, тэгээд энэ жилийн хувьд бол бас хэрэгцээгээ тодорхойлсон. Энэ хүрээндээ 2028-2030 оны түвшинд бол 88 мянган хүүхдийн шинээр ийм хэрэгцээ шаардлага бий болж байгаа. Энийг хангахын тулд 108 сургууль, 95 цэцэрлэг байхаас энэ жилийн тухайд бол зээлийн хөрөнгөөр ашиглалтыг нь оруулаад ингээд 41 сургууль, цэцэрлэгийн байр.

Юуг баримталж ингэж бас нэгэнт хязгаарлагдмал нөөцтэй байгаа учраас бас эрэмбэлээд хүн амын нягтаршил, ялангуяа бид нөгөө бүлэг дүүргэлт, стандартаас давсан бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициент нь 3 ээлж рүүгээ орчих гээд байгаа эрсдэлтэй, энийг багасгах үр дүн дээр суурилсан бодлогоор эрэмбэлсэн байгаа. Манай хөдөө, орон нутгийн тухайд бол ачаалал нь харьцангуй бага ч гэсэн .../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж 1 минут. 6 номер.

Х.Батжаргал: Бас нэг шаардлага, үзүүлэлт нь бол сургалтын үйл ажиллагаа явуулахад боломжгүй, эрсдэл хүлээсэн, цаашдаа бас тухайн сургууль, цэцэрлэгийн байрыг ашиглахад бас нэлээн хүндрэлтэй байдал үүсчихсэн, актлагдах дүгнэлт нь гарчихсан ийм нөхцөл байдлыг арилгахын тулд эрэмбэлж оруулсан байгаа.

Мэдээж бас Азийн хөгжлийн банкны өөрийнх нь шалгуур үзүүлэлт, нийгэм, жендер, тэгээд байгаль орчны үнэлгээ гээд ингээд маш олон үзүүлэлтүүд бол давхар бодогддог юм байна лээ. Ялангуяа манай нийслэл дээр бас нэг чухал асуудал бол газрын асуудал. Тэгэхээр энэ газрын асуудал бас бүрэн шийдэгдсэн байх нөхцөл байдлыг тавьж байгаа. Урьдчилсан төлөвлөлтөөрөө бол манай нийслэлээс энэ шаардлагатай байгаа хэрэгцээ шаардлагаа тодорхойлоод, газрынхаа асуудлыг шилжүүлж авах, чөлөөлөх зардал төсвөө тооцоолоод ингэж оруулж ирсэн байгаа.

Р.Сэддорж: Онцгой байдлын ерөнхий газар. Хэдэн номер вэ.1 номер нэг.

Я.Гантөмөр: Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Гантөмөр илтгэж байна. Монгол Улсад сөрөн тэсрүүлэх чадавхыг сайжруулах төслийн хүрээнд онцгой байдлын байгууллага бол 4 зорилтыг тавьсан. Үүнд,

1.Гал түймэртэй тэмцэх, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны чадавхыг сайжруулах,

2.Онцгой байдлын байгууллагын академик сургалт, бэлтгэлийн цогцолборын төвийг байгуулж, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, бэлтгэлжилтийг дээшлүүлэх,

3 дугаарт нь орон нутгийн засаг захиргааны байгууллага болон иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах,

4 дүгээрт нь Гамшиг судлалын хүрээлэнгийн Аюулгүй байдлын лабораторийн төвийн чадавхыг дээшлүүлэх гэсэн ийм 4 чиглэлээр бол төслийн үр дүн гарна гэж үзэж байгаа.

Сая Бадамсүрэн гишүүн асуулаа. Нисдэг тэрэгний тухай. Энээ нисдэг тэрэгний тухай асуудлаар Азийн хөгжлийн банктai санал .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер 1 минут.

Я.Гантөмөр: Азийн хөгжлийн банктai санал солилцоход бол нисдэг тэргийг санхүүжүүлэх боломжгүй гэсэн урьдчилсан байдлаар хариу өгсөн байгаа. Энэ чиглэлээр бол Францын Засгийн газартай ажиллаж байсан туршлагынхаа хүрээнд цаашид хамтран ажиллах саналаа хүргүүлээд байна.

Р.Сэддорж: Хөдөө аж ахуйн яам байгаа юу. 6 номер хариул даа.

Х.Батжаргал: Зээлийн бас тодорхой нэг хэсэг буюу одоо 20 сая долларын энэ санхүүжилтээр бол хөдөлмөрийн зах зээл, эрэлтэд нийцсэн ийм нийлүүлэлтийг хангах, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн болон техникийн боловсролын салбарынхаа дэд бүтцийг бий болгох, дундын дадлагын бааз, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуй руу чиглэсэн ийм төлөвлөлтийг хийж зарцуулахаар орж ирсэн байгаа.

Ялангуяа энэ гол төслийн санхүүжилт хүлээн авагч бол манай энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, политехникийн коллежуудын үйл ажиллагаа идэвхжиж, эрчимжиж, холбогдох дэд бүтцүүд, дадлагын баазууд шинэ технологийг нэвтрүүлж, хүний нөөцийг бэлтгэх энэ боломжийг нээх зорилгоор төсөл төлөвлөгдсөн байгаа.

Р.Сэддорж: Одоо тэгээд энэ гишүүдийн асуугаад байгаа Сангийн яам мэдээллээ хэрхэн яаж энэ зээлийг авах болсон, ямар шалгуур эрэмбээр эрэмбэлсэн эд нарыгаа бичгээр гаргаж өгөх хэрэгтэй байна. Одоо Бадамсүрэн гишүүн. Ялангуяа яамнууд энэ эрэмбэлсэн аргачлалаа бид нарт бичгээр гаргаж өг. Аль аль аймгуудыг яаж сонгосон юм. Тэгээд ямар аргачлалаар сонгосон юм гэдгээ бичгээр гаргаж өгөөрэй. Жишээ нь Цагаан хаданд эмнэлэг барих зүйл орсон уу. Эрэмбэлэх юм бол Монголын 21 аймаг, 9 дүүргийн хүмүүс тэнд ажилгүй хүмүүс нь тэнд яваад ажилтай, орлоготой байхын тулд тэнд явж байгаа гэх жишээний. Тэр дээр анхаарч хариултаа бэлдэж байгаач ээ. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Зээлийн хэлэлцээр дээр 4 чиглэлээр багцалж орж ирж байгаа энэ хэлэлцээр. Эрүүл мэндийн салбарын хувьд бол эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чиглэлээр, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн нэгжүүдийг чадавхжуулах, бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдэх ийм төсөл байна гэж харж байгаа. Үнэхээр яаралтай тусламжийг бол сайжруулах зайлшгүй

шаардлагатай эрүүл мэндийн салбар. Хамгийн гол нь энэ орж ирж байгаа тоног төхөөрөмжийн үнэ ханш ямар үнээр орж ирж байна вэ гэдэг дээр л бид нар анхаарах ёстой. Хэрэгтэй юм гээд аваад байдаг. Энийг хэн нийлүүлэх юм бэ гэдэг дээр анхаармаар байна. Хэн нийлүүлэх юм, хэн барих юм.

Сургууль мөн ялгаагүй. Бид нар зээлийн хэлэлцээр хийнгүүт заавал нөгөө айлын талаас гүйцэтгэл хийдэг гээд л нэг баахан өндөр өртөгтэй юмнууд орж ирээд, эргээд хүүгээ төлөөд харахаар ямар ч эдийн засгийн хувьд гэдэг юм уу үр ашиггүй, тэр төлсөн хүүгийнхээ мөнгөөр өөрсдөө хэчнээн юм хийчих хэмжээний ийм алдагдал үүрч болохгүй гэдгийг л би анхааруулахын тулд энэ тодорхой үнэ ханшийн мэдээлэл судалгаа байна уу гэдгийг тодруулмаар байна. Аль алинд нь. 1.

2 дугаарт боловсролын салбар 2026 онд 117 сургууль, 74 цэцэрлэг улсын төсөв болон зээл тусламж, гаднын зээл тусламж энэ санхүүжилтийн дүнгээр хийхээр төлөвлөсөн гэж байгаа юм. Тэгээд сая бол зээлийн хэлэлцээрт багтаж байгаа сургууль, цэцэрлэгүүдийг аймгуудад хуваарилсан байна л даа. 2026 онд хийгдэж байгаа нийт хөрөнгө оруулалтыг аймгаар нь Боловсролын яамны мэдээлснээр ингээд аймаг болгоноор хуваахаар энэ 117 сургуулийн үндсэндээ Улаанбаатар 40 байх нь аргагүй л байх л даа. Хамгийн өндөр дүнтэй байгаа аймгуудыг ингээд түүгээд харъя. Төв аймаг 7 сургууль, Өвөрхангай 5 сургууль, Дархан-Уул 5 сургууль, Говь-Алтай 5 сургууль, Хөвсгөл 8 сургууль. Одоо үргэлжилж байгаа нь гэсэн үг. Цэцэрлэгийг аваад үзэхэд Архангайн 12 цэцэрлэг хамгийн өндөр нь. Тэгэхээр 1 ангид ноогдож байгаа хүүхдийн тоогоор хүн амын тоогоор ачаалал нь ямар байгаа юм бэ гэдэг дээр яагаад ийм зүйл орж байгаа юм бэ. Би Орхон аймгийг жишээ болгож хэлэх гээд байгаа юм. 2026 оны төсөвт нийтдээ 3 сургууль, 1 цэцэрлэг үргэлжлэх юм байна. Шинэ юм байхгүй. Сая харин зээлийн хэлэлцээр дээрээс 1 сургууль тавьсан харагдана лээ. Гэтэл Орхон аймгийн нөхцөл байдал өнөөдөр яг Улаанбаатар шиг 1 ангид 50, 60 хүүхэд сууж байна. Самбарынх нь урдуур хүүхдийн хичээлийн ширээ 2-ын дундуур багш явах л зайтай сууж байна шүү дээ. Шилэн хүзүү нь татчихаа алдаад сууж байна шүү дээ. Гэтэл бусад аймгуудынхаа та нар хүн амын тоонд харьцуулаад хар л даа. Яагаад ийм ялгаатай байгаа юм. Тэгээд яагаад хэрэгжиж байгаа төслүүдийг нь үргэлжлүүлэхгүй, төсвийг нь хааж хаячхаад, зээлийн дүнгээр тавьсан гэдгээр ам хаагаад байгаа юм. Боловсролын яам бол энэ дээр тодорхой хариултаа өгөх ёстой.

Р.Сэддорж: Хариулт 6 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Батжаргал Боловсролын яам. Тэгэхээр энэ улсын төсвийн хөрөнгөөр улсын төсөвт өргөн баригдсан 198 төсөл бол 32 нь шинэ, үлдсэн нь бол шилжих хөрөнгө оруулалтууд байгаа. Тэгээд өнгөрсөн жилүүдэд хэрэгжиж байсан, бас дуусгаж амжаагүй, тодорхой саатал магадлалаар төсөв тоо хэмжээ нэмэгдсэн эдгээр асуудлуудыг шийдвэрлэх хугацаанд бэлэн байдал нь хангагдаад, магадлалаар баталгаажсан эдгээр ажлуудаа бол бид 198 төсөлдөө ингэж оруулж ирсэн байгаа юм. Зүгээр зээлийн хөрөнгөөр барих нь бол бас харьцангуй бас дийлэнх нь ачаалал өндөртэй, нягтаршил ихтэй байгаа, шаардлага хангаж байгаа тэр төслүүдээ бол Улаанбаатар хотоос түлхүү бол оруулсан нь үнэн.

Орхон аймгийн тухайд 3 төсөл арга хэмжээ бас сааталтай, нийт бол 5 арга хэмжээ явж байгаа. Тэгэхээр эдгээр нь өмнө нь хийгдэж байгаа гол шалтгаан нь төсөвт өртгийн тоо хэмжээ нэмэгдээд, магадлалаар баталгаажсан гэж байгаа

боловч төсөв өргөн барих үед баталгаажсан мэдээлэл нь бол шаардлага хангагдаж ирээгүй учраас байгаа.

Хоёрдугаарх нь барилгын гүйцэтгэгчээс шалтгаалсан одоо яг үнэндээ шууд хэлэхэд бол барилгын ажлаа гүйцээж чадалгүйгээр орхиод явчихсан. Араас нь бараг хууль хяналтын байгууллагад ч хандах хэмжээнд хүрчихсэн ийм компани бас байгаа. Тэгэхээр энэ асуудал маань өөрөө шийдэгдэж байж төсвийн шаардлага хангагдаж байж төсөвт орох ёстой учраас эдгээр шаардлага нь төсвийн өргөн барих 7 сарын 25-ны энэ хугацаанд бол шилжих зарим нэгэн асуулт бол үлдсэн байдаг юм. Асуудлууд нь.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Үгүй ээ, ямар хэцүү юм бэ Боловсролын яам. Би чуулган дээр бүүр баримттай, факттай тодорхой хэлсэн. Боловсролын сайд, танай Наранбаяр сайдад би энэ материалуудыг бүгдийг нь явуулсан. Юун 7 сард материал нь ирээгүй байсан гээд юу яриад байгаа юм бэ. Магадлалаар ороод, магадлалыг 2 жилийн дотор хийчихсэн. Магадлалынх нь дүнд аудит ороод баталгаажуулчихсан. 2025 оны төсөв дээр суулгаад оруулаад ирсэн юмыг танай яам эрхээ шилжүүлэхгүй, тендерийг нь зарлаагүй. Тэгээд 2026 оны төсөв дээр дахиад хасаад хаячихсан. Тэгээд төсвийн шаардлага хангаагүй гээд. Тэгээд яах юм. Энэ аудит чинь яах ёстой юм. Жил болгон бүх юманд аудит хийх ёстой юм уу. Аудит хийгээд 2 жилийн хугацаа нь өнөөдөр ч дуусаагүй явж байна шүү дээ. Үгүй ээ яагаад та нар ингэж хандаад байгаа юм бэ. Энэ боловсролын салбарын асуудлаас болоод бараг энэ зээлийн хэлэлцээр чинь унах нь байна шүү гэж хэлмээр байна. Тэгээд өнөөдөр энэ хэлэлцээр дотор чинь бүх аймгуудад хуваарилаад оруулаад ирчихсэн. Тэгээд тэрийгээ харьцуулаад та нар хар л даа. Ингэж болохгүй шүү дээ.

Р.Сэддорж: Хариулах хүн байна уу. Уянга гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Уянга: Энэ хөнгөлөлттэй зээлтэй холбоотойгоор 4 агуулга ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Тэгээд Үүрийнтуяа гишүүнтэй зарим агуулгуудаар бол яг санал нэгдэж байгаа. Яаж аймгуудаа, сумуудаа сонгосон юм гэдэг дээр бол дэлгэрэнгүй бас ярилцмаар байх юм.

2 зүйл дээр асуулт байгаа. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар. Тэгээд Боловсролын сайд бол байхгүй байгаа юм байна л даа. Тэгэхдээ хариулчих байх.

Аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл гэж байгаа юм. Төслийн хүрээнд хүрэх үр дүн гээд энэ хүрэх үр дүнг нь сонирхоод уншсан чинь ингэж байгаа юм. Ер нь бол яг энэ төсөл та хэдийн маань төлөвлөснөөр хэрэгжсэнээр 5 жилийн дотор урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтыг 26 хүртэлх хувиар бууруулна. Ер нь бол 5 хүртэлх жил бид нар чинь 1 жилийн дараахан харахад л хэцүү байгаа үед 5 жилийн дотор бүр 26 шүү. 25 биш, 4 биш, 30 биш, 31 ч биш. Энийг яг яаж бодсон юм. Энэ бодолтыг нь яг хармаар байна.

Хоёрдугаарх нь болохоороо энэ цэцэрлэг, сургуультай холбоотойгоор яг өгүүлбэр нь бол ийм байгаа юм. Эдийн засгийн хүндрэлийн үед шүү. Алдагдалтай төсөв баталж байгаагаа бүгдээрээ хүндрэл гэх үү, геополитикийн нөхцөлөө хүндрэл гэх үү. Боловсролын чанар хүртээмжийг сайжруулна. 2 дахь үе нэмэлт санхүүжилт

гэж байгаа юм. Яах вэ тэгээд зээлийн хүү нь бол их дажгүй л юм байна лээ л дээ. Дэмжээд явахад уг нь. Тэгээд боловсролын чанар гэдэг зүйлийг хэр оруулж өгсөн юм. Энэ дээр хариулт авъя. Сая өнгөрсөн 7 хоногт бол Дорноговь аймгийн Сайхандулаан сум дээр очиж ажилласан. Иргэдтэй уулзаад. Тэгэхэд хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Батчимэг гээд бүсгүй зовлонгоо ярьж байгаа байхгүй юу. Чанартай холбоотой шүү. Манай Төрийн нарийн бичгийн дарга байгаа Боловсролын яамны. Ингээд 2 удаа ариутгал хий гээд бид нарт шаарддага, тодорхой хугацаанд. Тэр мөнгө нь байдаггүй. Хувилбарт хөтөлбөр шаарддаг, тэр бас багш сурган хүмүүжүүлэхийн асуудал байдаг. Хоолны мөнгө нь 1 хүүхдэд 3 мянга байдаг. Тэгээд байгууллагад бас нэгдсэн архив, яг тэрэнд нь ажиллах хүн алга. Цалин бага байна гээд л ерөөсөө нөгөө чанартай холбоотой бүх зүйлүүд байгаа байхгүй юу. Тэгэнгүүт цэцэрлэг, сургуультай холбоотой та хэдийн юу хийх гэж байгааг нь харангуут ерөөсөө л бас л барилга л барих гээд байгаа байхгүй юу. Сургууль, цэцэрлэгийн. Ингээд цааш нь үргэлжлүүлээд харахаар хамгийн дээд тал нь л 960 хүүхэдтэй сургуулиуд барих юм байна. Мэдээж стандарт эд нар, тэрийгээ дагаад явж байгаа байлгүй. Миний энэ дээр бол асуух гээд байгаа юм нь дараа нь сум нэмж болох юм уу. Аймаг, сумын сонголтыг яаж нэмэх юм. Нэмбэл. Жишээ нь, Сайхандулаан сум дээр чанартай байдлыг нь хангасан, хүүхдийн тоог нь олшруулсан сум барья гэвэл яах вэ. Энэ дээр хариулт авъя.

Р.Сэддорж: Хариулт Чинбүрэн сайд. Улсын Их Хурлын гишүүн Тулгат, Лувсанжамц нарыг нэмье.

Ж.Чинбүрэн: Чухал асуулт асууж байна. Тэгэхээр түрүүн би хэлсэн тооцоолол байгаа. Эрчимт эмчилгээний хүртээмж, яаралтай тусламжаар тусламж авч чадаж байгаа эсэх, аймаг болгон дээр статистик мэдээлэл гардаг. Тэр дотроо түргэн тусламж очсон бол аварч болох нас баралт гэдэг тоон үзүүлэлт бас гарна. Тэгэхээр энэ болгон дээр тулгуурлаж бүх аймгуудад эрчимт эмчилгээ, яаралтай тусламж очиж чаддаг болсноор авчирсан хүмүүсээ эрчимт эмчилгээний тасагт шилжүүлээд, тэндээ төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлж чадсанаараа ийм үр дүнд гарна гэдэг ийм статистик тооцоон дээр гарч байгаа шүү. Манай анагаах ухааны нэг онцлог бол дандаа нотолгоонд тулгуурладаг. Хийсвэр тооцоолол байхгүй. 2024 оны нас баралтыг задалж үзээд, тэр дотор гарсан нөлөөллийг бид бууруулахад ямар үр дүн гарах вэ гэдэг нь л харагдаж байгаа юм. Тийм учраас энэ тоо бол аварч болох 6 мянган хүний нас баралт гэдэг бол нийт нас баралтын 30 хувь. Энэ бол гамшиг байхгүй юу. Энэ гамшигийг л арилгах том зорилго агуулж байгаа. Тийм тооцоололтой шүү.

Р.Сэддорж: 6 номер.

Х.Батжаргал: Боловсролын салбарт хэрэгжих энэ зээлийн төсөл өөрөө эдийн засгийн хүндрэлийн үед чанар, хүртээмжийг сайжруулах гэдэг нь ковидын үед анх эхэлсэн төсөл 50 сая долларын санхүүжилттэй эхлээд, дахиж нэмэлт санхүүжилт нь 15 сая доллароор мөн л адилхан сургууль, цэцэрлэгийн хүртээмж, барилга барьж байж л энэ хүртээмж нэмэгдсэн энэ орчныг нь сайжруулж байж, чанарын асуудал дагаж явдаг учраас яах аргагүй сургалтын орчин бол өөрөө чанартай шууд холбоотой. Гэхдээ бас таны асуусан чухал асуудал бол энэ чанарт бол угаасаа хүүхдийн хоолны шим тэжээл хүртэл нөлөөлдөг. Маш олон хүчин зүйлс байдаг. Шим тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд нийслэл дээр мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эцэг эхийг оролцоог хангаж, хяналтыг сайжруулаад, шим тэжээл нэмэгдээд 4 мянган төгрөгөөр явж байгаа.

Бас хувьсах зардлаар дамжуулаад энэ орон нутгийн хүүхдийн тооноосоо хамаараад очиж байгаа санхүүжилт нь бас харилцан адилгүй.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут нэмж өгье. 6 номер.

Х.Батжаргал: Тэгэхээр энэ зөвхөн чанар талаасаа бас нэмээд тодруулаад хэлэхэд зөвхөн бас барилга байшин гэхийн хажуугаар цахим контент, багш нарын ачааллыг бууруулах чиглэлээр энэ шинээр хэрэгжүүлэх гэж байгаа хөтөлбөрийнхөө бэлтгэл ажлыг хангах технологийн дэвшлийг ашигласан бас зарим нэгэн зардал төлөвлөлтүүд бол байгаа. Гэхдээ зээлийн хөрөнгө харьцангуй бас софт тал нь давамгайлах нь бол бас тийм өндөр үр дүнтэй бол бас байдаггүй гэдэг. Тийм учраас барилга байшинд бол түлхүү зарцуулчхаж байгаа.

Яг энэ 41 байршлын тухайд бол бас эргээд Азийн хөгжлийн банкны шалгуур шаардлагаар бас нарийвчилсан урьдчилсан судалгаа дүн шинжилгээнүүд бол дахиад хийгдэх юм. Тэгэхээр тэр дүн шинжилгээ явах шаардлага нь хангагдаад Азийн хөгжлийн банкны шалгуур шаардлагыг нь даваад, бидний бас эрэмбэлж байгаа тэр баримталж байгаа зарчимдаа нийцээд энэ өөрчлөлт бол .../минут дуусав/

Р.Сэддорж: Уянга гишүүн болчихсон уу. Лувсанжамц гишүүнийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Тулга.

Б.Тулга: Та бүхэндээ оройн мэндийг дахин хүргэе. Энэ аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжруулах, эрчимжүүлэх төслийн сонгогдсон орон нутаг, эмнэлгүүдийн жагсаалтыг гол нь харж байна. Тэгэхээр энэ дээр бол нөгөө ангиллаа авч үзэхдээ бүсийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, тэгээд сумын эмнэлэг гэсэн ийм ангиллууд хийчхээд, хамгийн доор нь буюу авто автомашины хөдөлгөөн ихтэй, дээр нь урсгал ихтэй дээр нь боомтын харилцаа сумууд гэдэг дээр хоосон байгаад байна. Яах вэ Боомтын үндэсний хороог татан буулгасан. Гэхдээ энэ юуг бол Сангийн яам хариуцаад явж байгаа. Эзэнтэй байгаа гэж би ойлгож байгаа. Тийм учраас энэ дээр түрүүн бас Байнгын хорооны дарга бас дурдах шиг боллоо. Монгол Улсын гол импортыг хийж байгаа Ганцмод-Гашуунсухайтын эргэн тойронд, тэр бүс нутагт боомтын ерөнхий төлөвлөлт гарсан байгаа. Тэр дотор байгаа эмнэлгүүдийг энэ дээр энийг уялдуулж болох уу.

Дээр нь дараа нь орох Өмнөговь аймгийн Гурван тэс сумын эмнэлэг орох уу. Мөн Сүхбаатар аймгийн Бичигт, Ховд аймгийн Булган боомт дээр бол бүтээн байгуулалт хийхээр хөрөнгө оруулалт шийдэгдсэн байгаа. Зүгээр эмнэлгийг нь бол энэ дээр суулгачихсан байх шиг байна. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум Бичигтийн боомтын талаар судалж, тийшээ эмнэлгийн төлөвлөлт оруулах ийм төлөвлөгөө байна уу гэдгийг асуумаар байна.

Р.Сэддорж: Хариулт Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр энд бичигдсэн зүйлээр зөвхөн 17 аймаг гэж битгий бодоорой. Энэ бол нийт Монгол Улс даяар хэрэгжих төсөл. Харин тэр боомтуудтай холбоотой асуудал дээр бол Хөгжлийн банкны барьцаанд байгаа эмнэлгийн барилгыг авах асуудлаа Цагаан хад дээр яригдаж байгаа шүү. Тийм учраас ингээд хийгдэх гэж байгаа, барих гэж байгаа төслүүдтэй холбоотой энд нэр нь ороогүй. Тэгэхээр нөгөө боомтууд, ялангуяа хүн амын төвлөрөл ихтэй газруудыг шийднэ гэсэн үндсэн том зорилго 2026 онд бид тавьчихсан байгаа. Тэгэхээр аль болохоор

энэ төсөл маань нөгөө юунуудтайгаа давхцах хөрөнгө оруулалт хийгдэхгүй байх ёстой. Түрүүн би хэллээ тийм ээ. Жишээлбэл Ховд, Увсад сая барилгын том төсөл 6-8 сая долларын хөрөнгө оруулалт Азийн хөгжлийн банкаар хийчихсэн байхгүй юу. Тэгэхлээр Азийн хөгжлийн банк Монгол Улс даяар эмнэлгүүдийн барилга, тоног төхөөрөмжийн шаардлагыг их сайн судалгаа хийчихсэн юм байна лээ. Бүр ТЭЗҮ-тэй. Хаана, юу хэрэгтэй шаардлагатай байгааг тооцоолчихсон. Тийм учраас энэ тооцооллынхоо дагуу нэмж барилга барих шаардлагагүй аймгуудын жагсаалтыг л сая харуулж байгаа шүү. Ер нь бол бүх аймагт машин, явдаг эмнэлэг, тоног төхөөрөмж, хүний нөөц бэлдэх ажил бол жигд хийгдэнэ. Энд бол ерөөсөө аймгийн ялгаа байхгүй. Миний нөгөө хэлээд байгаа гол зорилго бол ерөөсөө Монгол Улсынхаа нутаг дэвсгэр болон булан болгоныг орхихгүй байх, эмнэлгийн тусламж хүрдэг байх, Улаанбаатар хот руу ирдэггүй байх энэ тогтолцоог л аймгуудаар хийх л том зорилготой төсөл гэж ойлгохыг хүсье.

Р.Сэддорж: Тулга гишүүн тодруулъя.

Б.Тулга: Бүх аймагт хийхээс гадна, эрэмбэлэх ёстой л гэдэг зарчим яриад байгаа юм л даа. Эрэмбэлэх дотроо бол Монгол Улсын импорт, Монгол Улсад валют оруулж ирж байгаа гол аймгуудын сумууд, дээр нь бол боомтуудыг харьцуулж байна. Мэдээж хэрэг тэр эмнэлэг нэмж байгуулахад бол дэд бүтцийн асуудал шийдэгдсэн байх ёстой. 1 бол одоогийн байдлаар санхүүжилт нь шийдэгдээд, төлөвлөгдсөн байх ёстой. Үүнтэй уялдуулах ёстой. Үүнтэй санал 1 байна. Зүгээр Чинбүрэн сайдаас тодруулахад Цагаан хадан дээр ямар байрыг Хөгжлийн банк ямар эмнэлэг байгаа билээ. Эмнэлэг байхгүй санагдаад байх юм. Зүгээр цаад талд бол дулааны эх үүсвэр шинээр боомтын шинэтгэлийн хүрээнд баригдсан байгаа. Зүгээр тэр утгаараа Гашуунсухайт боомт дээр бол магадгүй харин дулааны эх үүсвэртэй болж байгаа учраас эмнэлэг төлөвлөж болох болов уу гэж бодож байна. Цагаан хадан дээр ямар эмнэлэг байгаа билээ. Эмнэлэг байхгүй санагдаад байх юм. Байхгүй биз дээ.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн баг бас нийтдээ 21 аймаг, 70 сумаар яваад үзчихсэн юм. Ямар боломж бүтээн байгуулалт хийж байгаа ажлуудын үр өгөөж нь ямар байна. Хаана, ямар боломж байна вэ гээд. Тэгээд тэнд бол 1 судалгаа хийж байгаа зүйл нь хувийн хэвшлийн барьсан барилгыг эмнэлгийн зориулалтаар ашиглах судалгаа явагдаж байгаа шүү. Тэр тэгэхээр тийм судалгаа тэр болохоор бол уг нь бол шууд Цагаан хаданд эмнэлгийн тусламж, нэг ёсондоо сумын эмнэлгийн хэмжээнд болгочих боломж байгаа юм байна гэдэг барилгын асуудал, тэрийг нь аваад тэгээд эмнэлэг болгоё гэсэн ийм санаачилга явж байгаа шүү.

Тэгэхдээ одоогоор яг бэлэн болчихоогүй учраас би танд шууд тэгнэ гэж хэлж чадахгүй байна. Ямар ч байсан судалгаа хийгдэж байна. Тийм боломж байгаа юм байна.

Р.Сэддорж: Тулга сайд. Энэ нөгөө тайван зогсоол гээд байсан шүү дээ. Тэр чинь Хөгжлийн банкаар баригдаад, тэгээд зээлээ төлж чадахгүй байгаа юм байна. Та тодруулах уу. 1 минут Тулга гишүүн.

Б.Тулга: Тэгэхээр яах вэ, нөгөө Хөгжлийн банк дээр байгаа юм чинь бас цаг хугацаа алдана шүү. Тэгэхээр бас их хугацаа орох байх. Зүгээр тэр судалгаатай зэрэгцээд нэгэнт энэ зээлийн хэлэлцээр яригдаж байгаа тохиолдолд 17 аймгийн

олон бас харьцангуй олон тоотой эмнэлэг яригдаж байгаа үед, дээр нь Гашуунсухайт боомт дээр бас дулааны эх үүсвэр ашиглалтад орсон байгаа учраас төлөвлөж өгөөч гэдэг хүсэлтийг л яриад байгаа юм. Энэ бол зөвхөн Өмнөговь аймгийн асуудал биш. Энэ бол Монгол Улсын стратегийн чухал ач холбогдолтой ийм бүс нутаг байгаа гэдгийг энэ ташрамд хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Очирбат.

Г.Очирбат: Оройн мэнд хүргэе. Энэ ингээд 475 сая долларын ерөнхий зээлийн хөтөлбөр гээд оруулаад ирж байгаа юм. Тэгээд энэ 4 чиглэлд хуваачихсан. Өнөөдөр Эрүүл мэндийн сайд энд сууж байна. Минийхээр энэ бол 475 сая доллар гэдэг бол 1,7 их наяд төгрөгийн асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ хариуцсан сайд нар нь орж ирэх ёстой. Энийгээ нэг бүрчлэн деталь ярилцъя. Тэгэхгүй бол энэ чинь бүр үнэхээр бас утгаа алдсан ийм мэдээллүүд бас байна шүү. Ялангуяа энэ Боловсролын яамтай холбоотой төсөвт өртгүүдийн зүгээр ингээд хамаа замбараагүй, зүгээр л 16 тэрбум 265 сая гээд ингээд тавьчихсан. Орхон аймгийн Баян-Өндөр сум дээр адилхан Улаанбаатар хотын Баянгол дүүргийн сургууль адилхан, Улаанбаатар хотын Налайх дүүргийн цэцэрлэг, Завхан аймгийн Улиастай хотын цэцэрлэг 150 хүүхэдтэй 3 тэрбум 641 сая. Тэгээд ийм харьцангуй байж болохгүй шүү дээ. Энэ дээрээ жоохон тооцоо судалгаатай ажиллаж, нягт үзэхгүй бол болохгүй. Салбарын сайд нараа дуудах хэрэгтэй байгаад байна.

2-т гэх юм бол энэ зээлийн ерөнхий хэлэлцээр дээр бас нэг ийм өгүүлбэр оруулчихсан. Түншлэлийн хөрөнгө оруулалтаар Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрт ноогдуулж буй нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвараас чөлөөлөх мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардлыг холбогдох улсын төсвөөс санхүүжүүлснийг тооцно гэхихсэн. Энэ олон арга хэмжээ болгон дээр чинь төслийн нэгж байгуулагдах гээд байна. Тэр болгон дээр чинь төсвөөс мөнгийг нь төлөөд явах уу. Үгүй ээ, тэгээд ийм замбараагүй. Би бол хувь гишүүнийхээ хувьд энийгээ жоохон деталь үзье. Ялангуяа Эрүүл мэндийн салбарыг дагуулж, бусад салбаруудыг ингэж оруулж ирж нийтэд нь 475 сая доллар, 1,7 их наяд гэж оруулж ирэхээ болих хэрэгтэй. Эрүүл мэндийн салбар эрүүл мэндийн салбарынхаа юмыг оруулж ирье. Барилга хот байгуулалтын яам нь тэрийгээ оруулж ирмээр байна. Энэ Шадар сайд магадгүй энэ Монгол Улсын гамшигтай холбоотой, сөрөн тэсвэрлэхтэй холбоотой юмнуудаа бас оруулж ирмээр байгаад байна. Ингэж сонсохгүй бол болохгүй. Тэгэхээр ер нь зарчмын хувьд энэ бол үнэхээр бас бүдүүлэг ерөнхий гэрээ оруулж ирж байна гэж харж байгаа шүү. Тэгээд асуултдаа ямар ч байсан хариулт авчихъя. Энэ улсын төсөв дээр хэдий хэмжээний дарамт учрах юм хойшдоо энийг асуучихъя.

2 дахь асуулт. Нийт зээл нь бол 475 гээд байгаа юм. Үүний 231,2 сая нь энгийн нөхцөлтэй зээл, үлдсэн 243,8 сая доллар нь хөнгөлөлттэй нөхцөлийн зээл гээд байгаа юм. Тэгээд энийгээ нийтэд нь хөнгөлөлттэй нөхцөлөөр авч болоогүй юм уу. Ийм 2 асуулт байна. Тэгээд тодруулъя.

Р.Сэддорж: Гарaa өргөөрэй. Хариулт 2 номер.

С.Тулга: Сангийн яам Тулга. Гишүүний асуултад хариулъя. Нөгөө зээлийн нөхцөлийн асуудлаар хариулъя. Азийн хөгжлийн банкнаас авч байгаа энэ зээлийн ерөнхийдөө 50 орчим хувь нь хөнгөлөлттэй эх үүсвэр байгаа. Тэгээд түрүүн би дурдсан. 2025 он хүртэл өрийн удирдлагын стратеги дээр юу гэж заасан байгаа вэ гэхээр нийгмийн шинж чанартай төслүүдийг хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлнэ гээд. Тэгээд ер нь бол Азийн хөгжлийн банкнаас 230 сая долларын

хөнгөлөлттэй эх үүсвэрийг аваад, манай улсад хуваарилсан хөнгөлөлттэй эх үүсвэрийн хэмжээ ингээд дуусаж байгаа. 475 сая доллар маань ерөнхийдөө үүгээр хязгаарлагдаад, ингээд 2028 он хүртэл дахиж Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад хөнгөлөлттэй эх үүсвэр хуваарилахгүй. Тэгэхээр энийг бол нэмэгдүүлэх боломж байхгүй байгаа юм гишүүн ээ. Зардлын хувьд бол хүүгийн зардал гарна. Төсөв дээр хамгийн том ирэх дарамт бол хүүгийн зардал байгаа. Тэгээд хөнгөлөлттэй эх үүсвэр дээр бол бид нар тогтмол 2%-ийн хүүгээр хүү төлнө. Энгийн эх үүсвэр дээр софер дээр нэмэх нь 0,6% гээд одоо 4,2 дээр 0,6% гээд 5 орчим хувь дээр хүү төлнө өө тэгээд зээлийн ашиглалт бүрэн гарсан тохиолдолд одоо хүүгийн зардал маань хамгийн өндөрдөө хөнгөлөлттэй эх үүсвэр буюу 243,8 сая ам.доллар дээр жилд 4,8 сая долларын хүү төлнө. Энгийн эх үүсвэр 231,2 сая ам.доллар дээр 2031 оноос бүх зээлийн ашиглалт гарсны дараа хамгийн дээд хэмжээ нь 10,4 сая ам.доллар төлнө. Тэгээд ерөнхийдөө бол хүүгийн төлбөрийг бид бол яг ашигласан дүн дээрээ төлдөг. Ашиглаагүй үлдэгдэл дээрээ болохоор бид нар хөрөнгө баталгаажуулсны төлбөр төлөөд явдаг ийм зохицуулалттай байгаа.

Тэр нэг гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлж байгаа шалтгаан нь бол бид орж ирж байгаа бараа бүтээгдэхүүн дээр гааль, НӨАТ-аас чөлөөлж байгаа. Энийг чөлөөлөхгүй байж болно. Чөлөөлөхгүй байх юм бол манай авах зээлийн хэмжээ нь л тэр дүнгээр нэмэгдэх учраас өөрөөр хэлбэл төлж байгаа зээл дээрээ татвар тавьж байна гэсэн агуулгаар ингэж чөлөөлж байгаа.

Р.Сэддорж: 1 номер нэмж хариулъя. Очирбат гишүүний асуултад хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Сангийн яам Дэлгэржаргал. Гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашгийг сайжруулах хүрээнд 1 авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бол энэ төслийн нэгжтэй холбоотой. Одоо яг явж байгаа төслүүд бол бүх төсөл төслийн нэгжтэй яваад байгаа. Өнгөрсөн 7 сард бид нар яг энэ дээр судалгаа хийгээд, Засгийн газрын тогтоол гаргаад, нэгдсэн төслийн нэгж гэдэг бүтэц рүү шилжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл салбар дээр тухайн гадаад зээл, тусламжийн төслүүдийг хариуцсан 1 л төслийн нэгж байна. Энэ бүх төслүүдээ хариуцаад явна. Тэгэхээр энэ тоогоороо бол орон тоо 60 хувь буурна. Дээрээс нь урсгал зардлыг зөвхөн 2025 оны түвшнээр 11 тэрбум хэмнэхээр байгаа. Төслийн нэгжүүдийн хувьд бол одоо зээлийн гэрээ хэлэлцээр дээрээ тухайн төслийн нэгжийг донороос санхүүжүүлэх үү, эсвэл улсын төсвөөс байх уу. Олон талт дээр бол эхэндээ гадаад зээл, тусламжийн санхүүжилт дээрээ явдаг. 2 талт зээлүүдийн хувьд бол Монголын тал хариуцаад явдаг. Тэгэхээр энэ төслийн хувьд одоо нэгдсэн төслийн нэгж рүү шилжүүлээд, нэгдсэн төслийн нэгж дээрээ энэ/минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Төсөл болгон дээр биш салбар болгон дээр 1 л нэгдсэн төслийн нэгж байна гэсэн үг. Тэгэхээр Эрчим хүчний яам жишээлбэл 9 төсөлд 9 төслийн нэгж байгаа бол 1 болно. Боловсролын яам бас 1 л төслийн нэгж. Энэ төслийн нэгж нь энэ төслөө цааш нь хариуцаад явна. Тэгэхээр зардлын хувьд болон орон тооны хувьд бол маш их хэмнэлт бий болгож байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Тэгээд мэдээж төрийн нарийн, мэргэжилтнүүд, дарга нар орж ирээд асуултад хариулж байх шиг байна. Тэгээд гол нь сайд нараа дуудах хэрэгтэй байна. Ер нь Байнгын хорооны хурал ингээд л болдог. Сүүлийн үед энэ сайд нар

ерөөсөө орж ирдэггүй. Асуултад хариулдаггүй ингээд бултаад алга болдог. Дараа нь хариуцлагыг нь хэн хүлээх вэ. Урьд нь бол төрийн нарийн, дэд сайд эд нар яг сууж байгаад хар толгойгоороо хариуцдаг байсан шүү дээ. Одоо тийм юм байхгүй болсон. Тэгээд энэ өрөөнөөс гарахаараа нэг өөр юм ярьдаг. Орж ирэхээр нэг өөр юм ярьдаг болчихсон шүү. Тэгэхээр энэ 1,7 их наяд төгрөг гэдэг бол асар их мөнгө. Эрүүл мэндийн салбарыг далимдуулж орж ирж ерөнхий гэрээг энд батлуулна гэдэг бол зарчмыг буруу гэж харж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Тулга гишүүн.

Б.Тулга: Тэгэхээр энэ их олон гишүүдийн асуултад энэ 3, 4 салбарын хэлэлцээртэй холбоотой зээлийн хэлэлцээртэй холбоотой ийм зүйл асуугдаж байхад салбарын сайд нар алга байна. Тэгээд энэ байдлаараа хэрвээ санал хураалт ингээд үргэлжлээд явах юм бол энэ бүх асуудал чинь унахаар байна. Тэр Эдийн засгийн байнгын хороон дээр энэ асуудал унахад бол тийм таатай зүйл биш байх гэж би бодож байна. Тийм учраас энэ асуудлаа хойшлуулаад, сайд нарыг байлгаж байж асуултаа асууж, хариултаа авмаар байна.

Р.Сэддорж: Хойшлуулах эсэхийг санал хурааж байж, санал хураалт нь дэмжигдэж байж хойшлуулна. Бусдаар бол санал хураагаад, тэгээд Байнгын хорооны санал дэмжсэн, дэмжээгүй гээд явна. Одоо Батсүмбэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Ийм байна. Энэ Чинбүрэн сайд юмаа танилцуулж байгаад сайн байна. Эрүүл мэндийн салбар дээр бас харьцангуй юмнууд явах гээд байгаа. Тэр Азийн хөгжлийн банктэй явж байгаа төслүүдээ шуурхай явуулаарай. Очирбат дарга бас сайн мэдэж байгаа. Тэр нөгөө эмнэлгийн асуудлууд тийм ээ, нэлээн гяцсан юм байгаа. Энийг сайд төрийн нарийн 2 анхаарна биз дээ.

Сая Очирбат гишүүний яриад байгаа үнэн шүү дээ. Сайд нар нь мөнгө болохоороо гараад ирнэ хаанаас ч юм. Тэгээд гишүүн болгоны өрөөгөөр давхиад гүйнэ. Утсаар нь ярина. Ийм юм болохоор мэргэжилтнээ явуулчихна. Энэ хэрэгтэй төслүүд байх нь байна. Боловсролын яамны энэ салбарын асуудлаас болж энэ төсөл унана. Хамгийн боловсролгүй, хамгийн бүдүүлэг, хамгийн завхарсан, хамгийн ялзарчихсан яам бол Боловсролын яам болсон. Батжаргал та бол тэрний 1 хэсэг нь болсон байна. Худлаа маш их ярьж байна. Худлаа ярьдаг сайдтай, худлаа ярьдаг сайд нартай. Олон удаа энэ яам худлаа ярьж байгаа. Монголын боловсролын салбар доройтоод, дампуураад байж байхад хэлбэрдээд, шоудаад л явж байгаа ийм сайд нартай болсон. Боловсролын яам бол энэ дүгнэлтээ хийх ёстой шүү. Би тэр хавар Ерөнхий сайдад хэлж байсан. Энэ боловсролын яамны тэр сонгосон байдал, энэ мэдээллээ орж байгаа байдал, Төрийн нарийн бичгийн даргын асуултад хариулж байгаа байдал бол энэ яамны байгаа царай. Ийм учраас энэ төслийг дэмжихгүй. Боловсролын яаманд би хэлье. Худлаа ярина, хулхидна, төсөв хулгайлна, төсөв наймаална ийм яам болсон шүү нөхдүүд минь.

Р.Сэддорж: Гишүүдээ дуудъя. Ирцээ бүрдүүлье. Энэ хооронд гишүүд асуултаа асууж, хариултаа авъя. Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Сайн байцаана уу. Өдрийн мэнд хүргэе. Нийгмийн дэд бүтцийн нийлүүлэлтийг дэмжих төсөл санаачлаад ингээд хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх гээд явж байгаад бол баярлаж байна. Тэгээд чуулган дээр хэлж байсан. Уг нь замаа барих биш сургууль, цэцэрлэг, эмнэлгээ л төсвөөрөө барьчихмаар

байгаа юм. Тэгээд заавал зээл аваад сургууль, цэцэрлэг, хүүхдүүддээ, эрүүл мэндийн салбарын хүмүүстээ ингээд анхаарна гэдэг болбол жоохон улсын үеийн бодлогын хөгжлийн чиглэлийн хувьд бол буруу шүү гэж хэлмээр байна. Нийт 41 сургууль, цэцэрлэг барих юм байна. Нийслэлийн 5 дүүрэгт 17, Налайхад 1, орон нутагт 15 сургууль, 8 цэцэрлэг юм байна шүү дээ. Энэ 41 барилга байгууламжийг ногоон байдлаар буюу урсгал зардал ялангуяа халаалтын зардлыг нь хэмнэх байдлаар Юнисефтэй гэрээ хэлэлцээрийг Юнисефийн зүгээс жишээ нь одоо 5 тэрбумаар жишээлбэл сургуулийн барилга барья гэхэд ногоон болгоход шаардлагатай 500 сая төгрөгийг нь Юнисеф олгож болж байна. Үнэгүй өгч болж байна гэсэн зүйлийг ярьсан. Тэгээд Наранбаяр сайдтай яриад, таныг бас Юнисефтэй холбож өгсөн. Тэр ажил ер нь энэ дээр оролцоод явах боломж байна уу. Тэгэхгүй бол манай орон нутагт ялангуяа уурын зуухаар ажилладаг сургууль, цэцэрлэгийн барилга чинь урсгал зардлынх нь 70, 80 хувь нь түлш түлээнд яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ багасгахын тулд бид нар ийм эрчим хүчний хэмнэлттэй сургуулиуд нийлүүлэх шаардлагатай байна. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь нийслэлийн 5 дүүрэгт 17 сургууль гэж байна. Арай цөөхөн биш үү. Орон нутагт 15 гэж байна. Тэгэхээр нийслэл дээр 60, 70-аараа 1 ангид сууж байгаа шүү дээ. 1 ширээн дээр 3 хүүхэд сууж байгаа ийм нөхцөл байдалтай байгаа. Энэ 17 сургуулийг барьснаар хэдий хэмжээгээр нийслэлийн сургуулиудын ачаалал багасах вэ. Тэгээд байршлаа яаж тодорхойлсон юм бол. Нийслэлтэй ярилцаад ирэх жил 33 сургуулийг барья гээд байршил нь бүгдийг нь тодорхой болгоод өгсөн. Тэрийг та бүхэн нийслэлтэй ярилцсан болов уу гэдэг 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт 41 ийм сургууль, цэцэрлэг барилаа. Багш, ажилчид нь бэлэн байгаа юу. Хэдэн багш, цэцэрлэгийн багш нар хэрэгтэй болох вэ. Тэгээд энэтэйгээ уялдуулаад Сангийн яамнаас асууя. Энэ 41 сургууль, цэцэрлэг барилга байшинг барихаар урсгал зардал дээр багш нарын цалин ер нь хэр хэмжээнд орох вэ. Цаашдаа бид нар 108 сургууль, 95 цэцэрлэг гэж байгаа. Үүний хүрээнд та хэд маань тооцсон задаргаа, тооцоо байгаа болов уу.

Танилцуулга дээр байна. Орон нутгийн PISA түвшин хотынхоос 2,5 жилийн зөрүүтэй байна гэж байгаа. Орон нутагт бага байгаа шалтгаан нь орон нутагт чинь анги дүүргэлт тийм өндөр биш байгаа. Зүгээр багш нарын чадамжийн асуудал байгаа, сургалтын чанарын л асуудал байгаа. Түүнээс биш барилга байгууламжийн асуудал бол байхгүй шүү дээ. Гэтэл ингээд нийслэл дээр ингээд татвар төлдөг, ялангуяа Хан-Уул дүүрэгт амьдарч байгаа хүмүүс бол сургууль, цэцэрлэг, улсын юм бараг байхгүй. Энэ дээрээ ингээд хот төлөвлөлттэйгөө уялдуулаад энийг гаргамаар байгаа юм. Тэгээд хот төлөвлөлтийн талаасаа нийслэлтэй хэр их ярилцсан бэ гэдэг 5 дугаар асуулт.

Р.Сэддорж: Хариулт 6 номер. Тодорхой хариулаарай.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Батжаргал Боловсролын яам. Тэгэхээр таны асуусан Юнисефийн санаачилга бол маш чухал байгаа. Азийн хөгжлийн банкны тавьж байгаа шаардлага ч гэсэн ногоон барилга, дулааны алдагдал багатай агаарын бохирдолт сөрөг нөлөөлөл учруулдаггүй гэсэн ийм чухал шаардлага тавьж байгаа. Тэгэхээр энэ ерөнхий хэлэлцээр батлагдаад дараагийн ажлын хэсэг байгуулагдаад, Азийн хөгжлийн банкнаас ч гэсэн бас судалгааны баг ирж ажиллах юм байгаа юм. Тэгэхээр энэ түвшинд бол хэлэлцээрийн явцад бол Юнисефийн багтаа бас яг энэ төслийн дэмжлэгийг аваад ингээд хамтран ажиллах

бүрэн бололцоотой гэсэн урьдчилсан бас яриа хэлэлцээр хийсэн байгаа. Энэ маш чухал асуудал байгаа.

Орон нутгийн тухайд бас яг цэвэр ээлжийн коэффициент бүлэг дүүргэлт хэдийгээр бага байгаа боловч сургалтын орчинд саад учруулахуйц өөрөөр хэлэх юм бол нөгөө эрсдэл учрахаар зориулалтын бус барилга байдаг. Ашиглалтын хугацаа нь дуусчихсан. Тэгээд маш эрсдэлтэй хүнд нөхцөлд байгаа тэр сургуулиуд бол бас байгаад байгаа юм. Тэр асуудлуудыг бас эрэмбийнхээ нэгж шалгуур үзүүлэлт болгож авсан байгаа.

Нийслэлийн хувьд бол энэ тоо үзүүлэлт, хэрэгцээ шаардлага бол нийслэлийн тооноосоо хамтарч байгаад гаргасан тоонууд байгаа. Зүгээр дээр нь гол шаардлага бол нөгөө газрын ер нь төслийн бэлэн байдал хангагдах гол үзүүлэлт байгаа. Тэгэхээр нийслэл дээр бол бас нэлээн тулгамдсан асуудал бол газар чөлөөлөлтийн асуудал. Цаг хугацаа авдаг үе шаттай бас нэлээд ажил хийгдэх ёстой учраас тэрийгээ бас нийслэлийнхэн маань бас нэлээн тооцсон байгаа. Зарим нэг асуудал бол бас хугацаа орж, дараагийн ээлжид бас газрын чөлөөлөлтийн асуудал ер нь хүлээгдэж байгаа Газар чөлөөлөлт ер нь хамгийн чухал тулгамдсан асуудал байгаад байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт Сангийн яам 1 номер.

Ж.Дэлгэржаргал: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Одоо яг эрэлт хэрэгцээний хувьд бол 2 асуудал байгаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт талаасаа нэлээн маш олон зорилтууд тавьчихсан. Тухайлбал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нийтдээ 214 их наядын хэрэгцээ шаардлагатай. Энэ дотроо мэдээж улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр бага, нөгөө талдаа зөвхөн 2026 оны жилийн төлөвлөгөө гэхэд бид нар 19 их наядын хэрэгцээний 3,6 төсвийн хөрөнгө оруулалт гээд яг нийгэм, эдийн засгийн хэрэгцээний хувьд бол 2028 он хүртэл бид нар дунджаар яг хүрэх түвшний хувьд ээлжийн коэффициентийг хамгийн дээд талдаа сургуулийг 2, цэцэрлэгийг 1,2 ч юм уу энэ хэмжээнд хүрэхэд 108 байршил байгаа. 108 байршлын 84 нь бол Улаанбаатар хот, 95 байршилд цэцэрлэг хэрэгтэй. 95 байршлын 59 нь эсрэгээрээ хөдөөдөө илүү цэцэрлэгийн хэрэгцээ өндөртэй байх жишээний. Яг энэ байршлуудаасаа бид нар эрэмбэлээд ингээд явж байгаа. Яг нийслэл дээр байгаа энэ 108 байршлын 84 нь бол нийслэлд байгаа. Энэ жил нийслэл 37 байршил дээр газар чөлөөлөлтийг .../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж хариулъя. 1 номер.

Ж.Дэлгэржаргал: Газар чөлөөлөлтийг үе шаттай хийгээд явж байгаа. Урсгал зардлын хувьд бол Боловсролын яам нэмж хариулах байх. Манай Сангийн сайдын баталсан аргачлалаар бол шинэ хөрөнгө оруулалт дээр бид нар нийт хөрөнгө оруулалтыг тооцохдоо барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж дээрээс нь яг ашиглалтын хугацаанд хэдий хэмжээний урсгал зардал гарах энэ тооцооллуудыг хийгээд явдаг. Тэгээд энд байгаа сургуулиудын хувьд бол цоо шинэ сургуулиас гадна өргөтгөж, одоо байгаа сургуулиудыг өргөтгөж барихтай холбоотой төслүүд дийлэнх нь орсон. Тэгээд энэ тохиолдолд бол одоо байгаа сургуулиудын ажлын байрны хувьд бол цоо шинэ гэхээсээ илүүтэй шилжин ажиллах тооцооллууд байгаа. Тэгэхээр нөгөө урсгал зардал дээр гарах тооцоолол дээр Боловсролын яам дэлгэрэнгүй байдлаар хариулах байх. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд

бол бид нар урсгал зардлыг тооцоод, яг ашиглалтад орох жил дээр нь урсгал зардлыг нь төсөв дээр тусгаад явдаг ийм тооцоололтой.

Р.Сэддорж: 6 номер хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя. Урсгал зардалтай холбоотой. Тэгэхээр шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгийн барилга ашиглалтад ороход давхар гарах урсгал зардал бол хүүхдийнхээ тоон дээр суурилсан буюу яг хувьсах зардлаар олгогдоод явчихдаг. Өөрөөр хэлэх юм бол бидний энэ төслийн үр дүнгээр бол 18,880 хүүхэд сургуульд хамрагдах бололцоо нэмэгдэнгүүт хүүхдийн тоогоо дагасан хувьсах зардал нь бэлэн тавигдаад явна. Хэдэн онд ашиглалтад орохоос шалтгаалаад тухайн жилийнхээ хувьсах зардал дээр суугаад явна гэсэн үг.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Тэгээд гол нь төлөвлөгөө байршлаа ингээд харахдаа эрсдэлтэй барилга байгаа учраас, хуучирчихсан барилга байгаа болохоор орон нутагт ингэж олноор нь төлөвлөж байна гэж байна. Эсрэгээрээ бид нар яг одоо нийслэлд байгаа 60, 70 хүүхэд сууж байгаа гэдгийгээ тооцохгүй бол эрсдэлтэй байна гэж хэлээд л орон нутагт баахан сургууль бариад байдаг. Тэнд хүүхдийнх нь тоо 1 ангидаа 30-аар сууж байгаа шүү дээ. Яг одоо бид нарт юу хэрэгтэй байгаа юм. Нийслэлд байгаа 60, 70-аараа ангидаа сууж байгаа энийг л цөөлөх хэрэгтэй. Тэгээд нийслэлд энэ 15 сургууль баригдсанаар энэ 60, 70-аараа ангидаа сууж байгаа сургуулиудын ачаалал аль аль сургуулиудынх буурах вэ. Тийм тооцоолол байгаа болов уу.

Р.Сэддорж: Хариулт. Хэдэн номер вэ. 6 номер.

Х.Батжаргал: Ачааллыг аваад үзвэл яах аргагүй нийслэл дээр бол нэн шаардлагатай байгаа. Гэхдээ одоо бид нар нөгөө үе шаттайгаар газар чөлөөлөлт нь хийгдээд, түүнийг дагасан бэлэн байдал нь хангагдангуут төслийн хамрагдалт, санхүүжилт, холбогдох бэлэн байдал нь хангагдсаны дагуу шаардагдаад явна гэсэн ийм тооцоололтойгоор бол эхний ээлжид өнөөдрийн энэ оруулж ирээд байгаа нийслэлийн 17 сургуулийн асуудал орж байгаа. Мэдээж газар чөлөөлөлтийн асуудал бол одоо шууд өнөөдөр бэлэн байдал нь бол хангагдсан гэвэл яг ийм байдлаар эрэмбэлж оруулж ирсэн байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл дээр нийтдээ ер нь 1,3 их наяд төгрөгийн алдагдалтай ажиллахаар төсөл орж ирсэн. Тэгээд 2026 онд бол Монгол Улс бол нийтдээ 3,7 их наяд төгрөгийг гадаадын улс орнуудаас авсан зээлийнхээ төлбөрт, үндсэн зээлийн төлбөр болон хүүнд төлж байгаа юм. Хүүгийн төлбөр нь бол 1,3 их наяд болж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын төсвийн алдагдал маань бол хүүгийнхээ төлбөртөө тэнцээд эхэлж байгаа юм. Тэгэхээр энэ бол өөрөө бид нар зээл дээр маш болгоомжтой хандах ёстой, зээлээ илүү үр ашигтай төсвөө зарцуулах ёстой гэдгийг бол харуулаад байгаа юм.

Азийн хөгжлийн банк бол манай улсын гадаадаас авсан зээлд бол хамгийн том зээлдүүлэгч юм байна. Нийт авсан зээлийн маань 63 хувийг зээлдүүлсэн. Нийтдээ 7,5 их наяд төгрөг зээлдүүлсэн байдаг юм байна. Тэгэхээр Азийн хөгжлийн банкны

авсан төслүүдийг бид нар ер нь эдийн засгийн хэдэн үр ашигтай төсөлд зарцуулсан бэ гэдэг 1 дүгээр асуулт Сангийн яамнаас.

Дараагаар нь болохоор бол 475 сая ам.доллар-ын маань 130 сая доллар нь л зөвхөн сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж болоод үлдсэн нь тоног төхөөрөмж болж байгаа юм. Тэгэхээр нягтлан бодох бүртгэлийн стандартаар болохоор тоног төхөөрөмж бол ер нь дунджаар 5-10 жилийн хугацаанд элэгдээд дуусдаг. Бид нар зээлээ 25 жилийн хугацаатай авч байгаа. Тэгэхээр яг энэ зээлээ төлж байх хугацаанд маань энэ тоног төхөөрөмжүүдийг бараг дахин 3-4 удаа худалдан авах шаардлага гарч ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар ийм тоног төхөөрөмжийг ингээд зээлээр санхүүжүүлээд яах юм бол цаашдаа бидний гол стратеги ямар байх юм бэ гэдэг ийм 2 дугаар асуулт байгаад байна.

Тэгээд хэрвээ үнэхээр тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх гэж байгаа бол үнэхээр маш чухал яаралтай тоног төхөөрөмжүүд нь хэдэн хувь нь юм бэ гэдэг ийм асуултуудыг асуумаар байна.

Р.Сэддорж: Хариулт 1 номер.

Ж.Дэлгэржаргал: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Азийн хөгжлийн банкны хувьд бол одоо яг хэрэгжиж байгаа төслүүдийн дийлэнх нь бол Азийн хөгжлийн банкны эх үүсвэр байгаа. Энэ дотроо дэд бүтцийн салбар бол дийлэнх нь байгаа. Энэ дотор эрчим хүчний салбар, Улаанбаатар хотын дэд бүтэц, орон сууцжуулалт, эрчим хүчний салбар дээр Азийн хөгжлийн банкны төслүүд хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр ер нь бол зээл тусламжийн төслүүдийн хувьд бол хамгийн том түнш бол Азийн хөгжлийн банк.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: 3 асуулт асуусан шүү дээ. 2 дахь асуулт бол энэ 475 сая долларын чинь 130 сая нь л барилга болоод байна. 40 жилийн хугацаатай барилга болж байгаа. Бусад нь болохоор бол дандаа тоног төхөөрөмж болж байна шүү дээ. Тэгэхээр тоног төхөөрөмж чинь өөрөө 5-10 жилийн хугацаанд ашиглагдаад элэгдэл нь дуусаад ингээд ашиглах боломжгүй болдог. Манай зээл 25 жилийн хугацаатай. Энэ хооронд бид нар бараг 3-4 удаа дахиад энэ 1,7 их наядыг авч байгаа шиг энэ зээлийг 2, 3 удаа авч байж энэ тоног төхөөрөмжөө дахин санхүүжүүлэх нь. Тэгэхээр бид нар ийм богино хугацаанд элэгдэл нь байдаг тоног төхөөрөмжүүд авахад ингэж зээл аваад байх юм уу л гэж асуугаад байхгүй юу. Манай энэ өрийн удирдлагын бодлого дээр юу бодож байна вэ. 2 дугаар асуулт нь ийм байсан шүү дээ.

3 дугаар асуулт болохоор үнэхээр энэ тоног төхөөрөмжүүдийг зайлшгүй, яаралтай тэгээд чухал байгаа учраас авах шаардлагатай байгаа гэдэг нь хэдэн хувь юм бэ гэж асуугаад байхгүй юу. Одоо жишээлбэл 20 сая долларын хөдөө аж ахуйн политехник коллеж эд нар үнэхээр шаардлагатай юу гэж бодохгүй л байна л даа.

Р.Сэддорж: Хариулт 2 номер. Гишүүд ээ, одоо горимын саналаар санал хураалт явах гэж байна.

С.Тулга: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тулга Сангийн яам. Соронзонболд гишүүн ээ, энэ эрүүл мэндийн салбар дээр барилга угсралтын зардал дээр 135 сая ам.доллар байгаа, тоног төхөөрөмж дээр 61,5 сая ам.доллар байгаа. Сургууль, цэцэрлэг дээр барилга угсралт дээр 110,3 сая ам.доллар байгаа.

Энэ дээр бол тоног төхөөрөмжийн зардал байхгүй байгаа. Политехник коллеж дээр барилга угсралтын зардал дээр 16,45 сая доллар нь барилга угсралт дээр байгаа. Тоног төхөөрөмж байхгүй. Онцгой байдал дээр 97, ерөнхийдөө онцгой байдлын тэр чигээрээ тоног төхөөрөмж байгаа. Тэр хүүгийн төлбөрийн хувьд бол хүүгийн төлбөрийг бол Засгийн газар ойрын жилүүдэд дандаа 1,2 их наядаас 1,3 их наядын түвшинд барьж ирсэн. Тухайлбал 2017 онд бид нар хүүгийн зардал дээр 1,2 их наядыг төлдөг байсан. 2024 онд бид нар бас 1,2 их наядыг төлж байна. Ирэх жилүүдэд бас хүүгийн зардал дээр 1,3 их наядаар төлөх юм байна гэсэн ийм тооцоололтой байгаа.

Р.Сэддорж: Сангийн сайд хариулах уу. Тэгвэл дараа нь хариулчих. Улсын Их Хурлын гишүүн Заяабал асуулт асууж, үг хэлнэ.

Б.Заяабал: Баярлалаа. Нийгмийн шинж чанартай ийм Азийн хөгжлийн банкны төсөл орж ирж байна. 475 сая долларын. Энийг бол би дэмжиж байгаа. Зээл авч хувийн хэвшлийн хийдэг ажлуудыг биш, яг нийгмийн шинж чанартай ийм ажлуудыг шийдвэрлэх үүднээс энэ зээлийг авч байгаа учраас энэ зээлийн хөтөлбөрийг би дэмжиж байгаа юм. Ингээд хэд хэдэн асуултууд асуучихъя.

1 дүгээрт нь энэ төслийн хэрэгжиж байгаа төслийн удирдлагын нэгжүүдийг яам болгон дээр 1, 1 болж төвлөрүүлсэн гэдэг зүйлийг сая бас Дэлгэржаргал дарга ярьчихлаа. Тэгээд үүнтэй холбоотой яам болгон дээр Дэлхийн банкны төслийг, Азийн хөгжлийн банкны төслийг, бусад санхүүжүүлэгчдийн төслүүдийг бүгдийг нь нэгтгээд 1 төслийн нэгж аваад явах юм уу. Тэгээд тендер зарлах болгонд нөгөө Дэлхийн банкны шаардлага procurement rule өөр, EDB өөр гэх мэтчилэн гээд худалдан авах ажиллагааны дүрмүүд нь бүгдээрээ өөр л дөө. Тэгээд тэрийг бүгдийг нь мэддэг ийм хүмүүс ажиллах хүч байгаа юу л гэсэн 1 дүгээр ийм асуулт.

2 дугаарт нь эмнэлэгтэй холбоотой асуултууд байна. Хөдөө орон нутгийн эмнэлгүүдийг чадваржуулъя, чадавхжуулъя, тоног төхөөрөмж нэмэгдүүлъя. Үүний цаана бол оношилгооны чанар сайжирна гэж би харж байна. Хөдөөгөөс хот руу ирдэг өвчтөний тоо буурах юм байна. Зайлшгүй шаардлагатай гэсэн хотод эмчлүүлэхээс өөр аргагүй ийм хүмүүс бол наашаа хот руу ирдэг ийм болох юм байна гэж ингэж үзэж байна. Хөдөө рүү бол нэлээдгүй эрүүл мэндийн төвүүдийг нэлээн чадавхжуулж, тоног төхөөрөмжийг нь сайжруулж, нэлээн явах юм байна л даа. Тэгээд нэлээдгүй их мөнгө зарцуулж байна. Би энэ дээр юу ярих гээд байна гэхээр эрүүл мэндийн салбарын зардлын асуудлыг ярих гээд байгаа юм. Тэнд хэчнээн хүн эмчлүүлж байгаа билээ. Улаанбаатар хотын төв эмнэлгүүд чинь очер нь дийлддэггүй. Гэтэл аймаг, орон нутгийн эмнэлгүүд дээр яваад үзэхэд үдээс хойш нь бараг эмч нар байхгүй, онгорхой өрөө байдаггүй л юм байна лээ шүү дээ. Зарим аймгууд дээр яваад үзэхэд. Тэгэхээр энэ ачааллуудыгаа яаж тэнцвэржүүлж явах юм бэ. Гэтэл улсын төв эмнэлгүүд дээр шинэ шинэ эмнэлгүүдийг дахиж барья гэдэг ийм зүйл орж ирээд байдаг. Цаана нь төсвийн үр ашиггүй зарцуулалт чинь нэмэгдээд байдаг ийм асуудал үүсэж байгаа юм биш үү гэж.

2 дугаарт нь боловсролын салбараас асуумаар байна. Энэ төслүүдийгээ эрэмбэлэхдээ аймаг, аймаг дунд нь эрэмбэлчихсэн юм уу. Эсвэл улсын хэмжээний ийм шалгуур үзүүлэлтийг гаргаж байгаад эрэмбэлсэн юм уу.

3 дугаарт нь МСҮТ-үүдийг чадавхжуулна гээд яриад байна. Энд ер нь хэр зэрэг үр ашигтай ажиллаж байгаа юм бэ. Суралцаж төгссөн хүмүүс ажлын байраар бүрэн хангагдаж чадаж байгаа юу, үгүй юу. Миний хувьд энэ МСҮТ-ийг энэ 9 дүгээр анги

төгссөн буюу хуучныхаар бол дунд ангаа төгссөн хүүхдүүдийг ахлах ангид нь МСҮТ-д ороод, тэндээсээ сайн сурсан хүүхдүүд нь дараа нь дээд сургууль руу орох, тэндээсээ мэргэжил эзэмшээд ажлын байр дээр гарах хүмүүсийг нь шууд бэлтгээд явуулдаг энэ систем байгаа юу.

4 дүгээрт нь энэ онцгой байдалтай .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Заяабал гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Төслийн нэгжтэй холбоотой асуултад хариулъя. Одоо яг хэрэгжиж байгаа төслүүдийн хүрээнд улсын хэмжээнд 46 төслийн нэгж дээр 474 хүн хөлсөөр ажиллах гэрээтэй ажиллаж байгаа. Тэгэхээр бид нар гадаад зээлийн үр ашгийг сайжруулах, яг нэгдсэн удирдлагатай болгох, энэ төслүүдийг хугацаанд нь дуусгах асуудал дээр бол төслийн нэгжийн зохион байгуулалт дээр анхаарах асуудал маш чухал байгаа. Тийм учраас Засгийн газрын тогтоол гараад, доноруудтайгаа маш олон удаа хэлэлцсэн. Нэгдсэн төслийн нэгжийн зохион байгуулалтад орсноор одоо хэрэгжиж байгаа төслүүдийн хувьд бол нэгдсэн төслийн нэгжид оруулахдаа тухайн салбар дахь төслийн нэгж дээр байгаа албан хаагчдын дунд зохион байгуулалт хийнэ. Цоо шинээр албан хаагч авахгүйгээр ингэж доноруудтайгаа тохирсон байгаа.

Тэгэхээр Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмууд бол мэдээж бүгд ялгаатай. Тэгэхээр энэ дээр худалдан авах ажиллагаа санхүү, дунд нь дэд зохицуулагчийг бий болгох байдлаар өнөөдөр яг Азийн хөгжлийн банктай хамгийн сүүлийн санал авах уулзалтаа хийгээд, Сангийн сайдын тушаалаар энэ тогтоолын хүрээнд нэгдсэн төслийн нэгжийн журам маань батлагдаад, 1 сарын 1-ээс бүх салбар дээр яг 1 л төслийн нэгж, эсрэгээрээ яг тогтвортой байдлыг хангахын тулд бид нар хөлсөөр ажиллах гэрээг 1 жилээр сунгадаг байсан бол 3 жилээр хийхээр ийм зохицуулалтуудыг хийж байгаа.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр Заяабал гишүүн бас зөв л өнцөг хөндөөд байна л даа. Ер нь ачаалал нь жигд тооцож чадаж байгаа юм уу гэдэг асуултад хариулъя. Тэгэхээр ерөөсөө эмнэлгийн ачаалал, эрүүл мэндийн салбарын том ачаа юу байдаг вэ гэхээр эрчимт эмчилгээ л байдаг. Яаралтай тусламж. Бусад нь архаг тусламжууд бол цаг авч байгаад, төлөвлөж байгаад эмчилгээ хийлгэж болдог. Яг амь тэнсэн үед яаж шуурхай эмчилж чадаж байна. Нөгөө амь тэнсэн хүнийг удаан хугацаагаар эрчимт эмчилгээнд тусламж үзүүлж чадаж байна уу гэдэг нь манай салбарын л гол ачаа. Тэгэхээр энэ ачаа орон нутгуудад 2,2 дахин бага байна. Нэг ёсондоо тийм ор байхгүй байгаад байгаа байхгүй юу. Цөөхөн хэдхэн ортой. Тийм учраас энэ төслийн гол зорилго бол ерөөсөө аймгууд дээрээ эрчимт эмчилгээний ортой болох, яаралтай тусламжийг үзүүлж чаддаг л болох гэж зорьж байгаа том төсөл юм.

Та түрүүн бас асуусан либералчлах чухал байна гээд. Тийм. Либералчлахад юу дутаад байна вэ гэхээр даатгалын санхүүжилт өөрөө хүрэхгүй байгаа учраас өнөөдөр бид хөрөнгө оруулалтыг дамжуулан эрүүл мэндийн ачааллыг даадаг болох орон .../минут дуусав/

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Батжаргал. Шаардлага, шалгуураа боловсролын салбарын хувьд бол улсын хэмжээнд нэгдсэн шаардлага, шалгуур бас Азийн хөгжлийн банкнаас гаргаж байгаа, тавьж байгаа шаардлагыг тавиад аймаг бүр дээрээ эрэмбэлж зохион байгуулалт хийсэн байгаа. Тухайлах юм бол Увс аймгийн Зүүнговь сумын энэ сургууль 320 хүүхэдтэй 593 хүүхэд сурч байгаа 320 хүүхдийн. Тэгээд энд нуралт үүсчихсэн. 51 жилийн насжилттай. Тэгээд маш хүнд байдалтай байгаа юм байна лээ. Тэгэхээр иймэрхүү байдалтай барилгатай сургууль, цэцэрлэгүүд бол аймгуудад бол нэлээд байгаа. Гэхдээ нэн тэргүүнд нэгэнт хязгаарлагдмал нөөцтэй учраас эрэмбэлж байгаад аймаг дээр нь эрэмбэлж оруулж ирж байгаа. Зүгээр мэргэжлийн боловсролын тухайд бид нар бас яагаад хөдөө аж ахуйн салбарыг сонгож авсан бэ гэхээр энэ маань өөрөө хамгийн их хүний нөөцийг шингээх ийм салбар байдаг хүний нөөцийг. Тэгтэл тэнд хүний нөөцийн дутагдал буюу заавал 4 жил их сургууль төгсөөд, бакалаврын дипломтой .../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж 1 минут 6 номер.

Х.Батжаргал: Богино хугацаанд яг мэргэжлийн шаардлага хангасан ийм дадлагын бааз дээр сургуулилтаа хийгээд, дадлагаа хийгээд ажлын байран дээр ажиллангаа суралцаад, суралцангаа ажиллах энэ нөхцөл байдал нь манай политехникийн коллежууд дээр үнэхээр дутагдалтай. Ер нь сүүлийн бараг 10, 20-оод жил энэ шинэчлэлийн ажлууд ер нь огт хийгдээгүй байсан. Гэтэл нөгөө талдаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нь богино хугацаанд сургаад төгсгөөд, ажилчдадаа бэлтгээд авъя гэхээр техникийн ажилчдын дутагдал бол асар өндөр. Эсрэгээрээ хөдөө аж ахуйн салбар өөрөө хамгийн их хүний нөөцийг шингээдэг салбар. Тэр утгаараа хөдөө аж ахуйн салбар хамгийн их тэргүүлэх салбар болж хөгжиж байгаа. Төвийн бүс дээр энэ зохион байгуулалтыг хийгээд ажиллаж байгаа.

Мэргэжлийн боловсон хүчин хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж байгаагийн хувьд мэргэжлийн боловсролын салбар 65-70 хувьтай хөдөлмөрийн зах зээл дээр очиж ажиллаж байна гэсэн ийм тооцоолол байгаа. Энийг бүр илүү богино хугацааны сургалтаар нэмэгдүүлэх шаардлага улам өсөөд байгаа.

Р.Сэддорж: Гишүүдээс горимын санал гарсан. Жишээ нь Боловсролын сайд алга байна. Онцгой байдлын Шадар сайд алга байна. Эдийн засаг, хөгжлийн сайд алга байна. Их хэмжээний зээлийн хэлэлцээр хамгийн чухал 2 Байнгын хороо Аюулгүй байдал, Эдийн засаг гэсэн 2 хороо. 1-ээр хэлэлцэж байна. Ганц Сангийн сайд л байна. Эрүүл мэндийн сайд байна. Эрүүл мэндийн сайд угаасаа байсан. Байнгын хорооны ирц санал хураалтад бүрдсэн байна. Тэгэхээр бид одоо горимын саналаар санал хураах. Тулга гишүүний гаргасан хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэсэн горимын саналаар ... Тийм дэг байхгүй. Горимын саналаар. Энэ зээлийн хэлэлцээрийн асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргасан. Гишүүд санал хураалтад бэлдье.

Байнгын хорооны дараагийн хуралдаан бол хэзээ тавигдах нь даргын зөвлөлийн хурлаар шийдэгдэнэ. Тэгээд ойрын үед тавигдаж магадгүй. Эсвэл дараагийн 1 дэхэд тавигдаж магадгүй. Ийм учраас Тулга гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлыг хойшлуулах. 65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ зээлийн хэлэлцээрийн асуудлыг дараагийн хурлаар хэлэлцэхээр шийдлээ. Зарим сайд нар байхгүй байна. Дараагийн хурлаар орно.

19.49 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудал 3.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг сонссонтой холбогдуулан Монголбанк дахь Үндэсний баялгийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар тогтоолоор байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сард өөрчлөлт орж, Байнгын хороо болон Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан мөн дээр дурдсан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалын хүсэлтийг үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд тараасан байгаа. Энэ тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Энэ бол ажлын хэсгийн даргыг өөрчилсөн асуудал байгаа. Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 7 дугаар тогтоолоор байгуулагдсан Монголбанк дахь Үндэсний баялгийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг доор дурдсанаар өөрчилсүгэй.

Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Жаргалан.

Ажлын хэсгийн ахлагчийг сольж байгаа ийм тогтоол байна. Бүрэлдэхүүн дээр саналтай гишүүд байна уу. Заяабал гишүүн.

Б.Заяабал: Би ажлын хэсэгт бас өөрийгөө оруулах саналтай байна. Нэмж би бас оръё. Танд би бас өмнө нь илэрхийлсэн.

Р.Сэддорж: Тогтоолын төсөл тараагдсан байх ёстой доо. Өмнө нь нөгөө Батнайрамдал гишүүнээр ахлуулсан тогтоолын төслийг Батнайрамдал гишүүн бүрэлдэхүүнд нь ороод, Бадамсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна. Ингээд Заяабал гишүүнийг нэмж байна. Алдаржавхлан гишүүн нэмэгдэж байна.

Бүрэлдэхүүнийг дахин уншаад санал хураалт явуулна. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Жаргалан, Заяабал, Алдаржавхлан, Сэддорж гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж байна. Энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт. 65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.51 цаг.

Хэлэлцэх асуудал 4.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад Байнгын хороо төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасан. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Очирбат горимын санал гаргаж байна.

Г.Очирбат: Горимын санал гаргая. Одоо ингээд оройны 8 цаг болчихдог. Энд гишүүд өдөржингөө хуралдсан. Олон асуудлуудыг бас өнөөдөр ярилаа. Тэгээд энэ төсөвтэй холбоотой асуудлыг хойшлуулбал яасан юм гэсэн горимын санал гаргаж байна. Одоо жоохон сэргэг, тархи толгойгоо ажиллуулж байгаад олон асуух асуулт байна. Бас олон сайд нар хэрэгтэй. Жавхлан сайд ерөөсөө бүх юман дээр ингээд ганцаараа явж байдаг. Мэдээж төрийн албан хаагч нараасаа бас уучлалт хүсье. Одоо 8 цаг болж байна шүү. Оройны 20 цаг өнгөрч байна. Тэгэхээр ийм болохоор энэ төсөвтэй холбоотой асуудлыг хойшлуулах горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү.

Р.Сэддорж: Очирбат гишүүний гаргасан горимын саналтай холбогдуулан санал хураалт явуулна. Жавхлан сайд ирцдээ орох хэрэгтэй. Ингээд гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улсын төсвийн тухай асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцье, зарим сайд нар байхгүй байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Очирбатын гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлыг хойшлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 52,2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төрийн албан хаагчдаасаа уучлал хүсэж байна. Бүлгийн хурлууд, намын бүлгүүдийн хурлууд маш удааширсан учраас одоо цаг хэтэрхий удааширсан байна гэж үзээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хурал үүгээр өндөрлөж байна.

Хуралд идэвхтэй оролцсон ажлын хэсгийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа.

19.53 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ